



UNODC

United Nations Office on Drugs and Crime

Туршилтын үнэлгээ хөтөлбөр: Монгол Улс

НҮБ-ын Авилгалын эсрэг Конвенцийн 5, 15, 16, 17, 25, 46 дахь зүйл, 9, 13, 52, 53 дахь заалтын хэрэгжилтийн үнэлгээ

Үнэлгээнд оролцсон улсууд:
Пакистан, Швед

А. Оршил

Авилгалын эсрэг НҮБ-ын конвенцийн 63 дахь зүйлийн дагуу уг конвенцийн хэрэгжилтийг дэмжих, хянах чиг үүргийг багтаасан оролцогч улсуудын бага хурал байгуулагдсан билээ. 63 дугаар зүйлийн 7-ийн дагуу тус бага хурал шаардлагатай гэж үзвэл конвенцийн хэрэгжилтийг хангах байгууллага буюу механизм бий болгох үүрэгтэй.

2006 оны 12 сард Йордан улсад зохион байгуулагдсан анхны хуралдаанаар оролцогч улсууд конвенцийн хэрэгжилтийг хянах үр нөлөөтэй механизм бий болгох шаардлагатай байгаа талаар санал нэгдсэн юм (Тогтоол 1/1). Тус хуралдаанаас бага хуралд тэрхүү механизмын талаар зөвлөх эрхтэй засгийн газар хоорондын шинжээчдийн нээлттэй бүлэг байгуулсан. Тэрхүү бүлэг нь бага хурлын чиг үүргийн бүрэн хэрэгжилтийг хангах, ялангуяа конвенцийг хэрэгжүүлэх чиглэлээрх улс орнуудын үйл ажиллагаанд нэгдсэн дүгнэлт хийхэд дэмжлэг үзүүлэх юм. Бага хурал НҮБ-ын нарийн бичгийн дарга нарын газарт өөрийн үнэлгээний мэдээлэл цуглуулах, тайлагнах, конвенцийг хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа дүн шинжилгээ хийхэд нь оролцогч улсуудад туслалцаа үзүүлэх хүсэлт тавьсан. Түүнчлэн хуралдааны үеэр хэд хэдэн улс орон конвенцийн хэрэгжилтийн хяналтын механизмд дэмжлэг үзүүлэхэд бэлэн байгаагаа илэрхийлсэн юм. Хяналтын механизмд өөрийн үнэлгээ багтах ба түүнд нь НҮБ-ын Нарийн бичгийн дарга нарын газраас дэмжлэг үзүүлэх юм.

Энэхүү тайлан нь Конвенцийн хэрэгжилтийн үнэлгээ хөтөлбөрийн нэг хэсэг бөгөөд конвенцийн хэрэгжилтийн үнэлгээг гүйцэтгэх аргачлалыг турших нэг боломж юм. Үүгээр туршин хэрэгжүүлж буй механизмын үр нөлөөт байдлыг үнэлэх, үнэлгээнээс авсан сургамж, туршлагын талаар оролцогч улсуудын бага хуралд мэдээлэх ерөнхий зорилгыг агуулж байгаа билээ. Ингэснээр бага хурал конвенцийн хэрэгжилтийг үнэлэх зохистой механизм бүрдүүлэх юм. Туршин хэрэгжүүлж буй хөтөлбөр нь үйл ажиллагааны чиглэлийг нарийвчлан зүгшрүүлэх завсрын арга хэмжээ болно. Үүнд зөвхөн сайн дурын үндсэнд оролцох ба хамрах хүрээ, цаг хугацааны хувьд хязгаартай билээ.

Туршилтын үнэлгээний хөтөлбөрт хэрэглэсэн аргачлал нь Авлигалын эсрэг конвенцийн хэрэгжилтийн үнэлгээг оролцогч улсуудад хязгаарлагдмал хүрээнд хийсэн бөгөөд чингэхдээ өөрийн үнэлгээ, бүлгийн ба шинжээчдийн үнэлгээг хослуулсан юм.

Үнэлгээний үйл ажиллагааны явцад бүлгийн гишүүд тодорхой улс оронтой харилцан ярилцах, өмнөх мэдээллийг хэлэлцэх, нэмэлт мэдээлэл гаргуулах зэргээр харилцан ажилладаг. Шаардлагатай тохиолдолд тухайн улс оронд хүрэлцэн очиж өөрийн үнэлгээнд нь туслах, түүнчлэн зөвлөмж боловсруулна. Улс оронд хүрэлцэн очих багууд нь урьдчилан тохиролцсон хоёр улсын шинжээчид болон Нарийн бичгийн дарга нарын газрын гишүүнээс бүрдэх юм.

Хяналт үнэлгээгээр дараах зүйл, заалтуудын хэрэгжилтийг авч үзнэ. Үүнд:
5-р зүйл (авлигаас урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагаа); 15-р зүйл (үндэсний түвшний төрийн албан тушаалтныг хахуульдах); 16-р зүйл (Гадаадын төрийн албан

тушаалтан болон олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах); 17-р зүйл (Төрийн албан тушаалтан эд хөрөнгө завших, ашиглан шамшигдуулах буюу бусад аргаар зориулалтын бусаар зарцуулах); 25-р зүйл (шүүн таслах ажиллагаанд саад учруулах); 46 (эрх зүйн харилцан туслалцаа); зүйл ангиудын тодорхой заалтууд: 13, 9; 52 (Гэмт хэргээс олсон орлогыг шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх), 53 (Эд хөрөнгийг шууд буцаан олгох).

B. Үйл ажиллагаа

НҮБ-ын Авилгалын эсрэг Конвенцийн Монгол Улс дахь хэрэгжилтийн үнэлгээг тус улсаас хүлээн авсан өөрийн үнэлгээ, Пакистан болон Швед улсын шинжээчид ба Монгол Улсын хоорондын харилцан ярианы үр дүн, бүсийн холбогдох хяналтын механизмын тайлангийн судалгаа, тухайлбал 2007 оны Ази Номхон Далайн бүлэг—Санхүүгийн зорилтот бүлгийн (Asia Pacific Group—Financial Action Task Force: APG-FATF) тайлан, мөн 2009 оны 4 сарын 20-22-нд Монгол Улсад ажилласан томиллод үндэслэн гүйцэтгэсэн. Монгол Улсад ажиллах үеэр АТГ, Хууль Зүй Дотоод Хэргийн Яам, Гадаад Харилцааны Яам, Монгол Банк, Сангийн Яам, Үндэсний Аудитын Газар, Ерөнхий Прокурорын газар, Дээд Шүүх, Globe International ТББ, Монголын Уул уурхайн ил тод байдлын санаачилгын Үндэсний зохицуулагч, Төрийн үйлчилгээний зөвлөл зэрэг байгууллагатай уулзалт хийсэн.

C. Гүйцэтгэлийн товчоо

Монгол Улс НҮБ-ын Авилгалын эсрэг конвенцийн 46 дахь зүйл (эрх зүйн харилцан туслалцаа), түүний 9, 13 дахь заалтын дагуух шаардлагатай бүх арга хэмжээг авчээ. Мөн Авлигын эсрэг конвенцийн 5 дахь зүйлийн (авлигаас урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагаа) шаардлагыг байнга хангаж байх арга хэмжээ авч байна. Тус улс мөн конвенцийн 17-р зүйл (Төрийн албан тушаалтан эд хөрөнгө завших, ашиглан шамшигдуулах буюу бусад аргаар зориулалтын бусаар зарцуулах), 52-р зүйлийн (Гэмт хэргээс олсон орлогыг шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх, шилжүүлгийг илрүүлэх) хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа явуулж байна.

Харин тус улс Авилгалын эсрэг конвенцийн 15-р зүйл (Үндэсний төрийн албан тушаалтныг хахуульдах), 25-р зүйл (Шүүн таслах ажиллагаанд саад учруулах), 53-р зүйлийн (Эд хөрөнгийг шууд буцаан олгох арга хэмжээ) шаардлагыг хангах талаар зөвхөн зарим нэг арга хэмжээ л авсан байна. Монгол Улс Авилгалын эсрэг конвенцийн 16-р зүйлийн (Гадаадын төрийн албан тушаалтан болон олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах) шаардлагыг хангах чиглэлээр арга хэмжээ аваагүй байна.

D. НҮБ-ын Авилгалын эсрэг конвенцийн хэрэгжилт

1. Конвенцид нэгдэн орсон нь

Монгол Улс 2005 оны 4 сарын 29-ний өдөр конвенцид гарын үсэг зурсан (UN Doc. No. C.N.323.2005.TREATIES-11.) Монгол Улс 2006 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр уг

конвенцид нэгдэн орсон. (UN Doc No. C.N.9.2006.TREATIES-1.) Конвенцийн шаардлагын дагуу арга хэмжээнүүдийг бүрэн хэрэгжүүлэхийн тулд Монгол Улс 2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр Авлигын эсрэг хуулиа шинэчлэн баталсан бөгөөд 2006 оны 11 сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

2. Монгол Улсын эрх зүйн тогтолцоо

Монгол Улсын Үндсэн Хуулийн 10-р зүйлийн 3 дахь заалтад “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж заасан байдаг. Иймд Авилгалын эсрэг конвенц нь Монгол Улсын хуулиудын хүрээнд дээгүүр байр эзлэх ба тус улсын эрх зүйн тогтолцооны салшгүй хэсэг болно.

Монгол Улсын Ерөнхийлөгч төрийн тэргүүн, Засгийн газрыг Ерөнхий сайд тэргүүлдэг бөгөөд Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр танхимын гишүүдийг томилох саналаа хууль тогтоох байгууллагад өргөн мэдүүлдэг. Монгол Улс нэг танхимт парламенттай (Улсын Их Хурал). Дээд Шүүх нь шүүхийн дээд байгууллага бөгөөд Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар, бусад шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор Ерөнхийлөгч томилдог.

Монгол Улсын Авлигын эсрэг шинэ хуулийн дагуу 2006 онд Монгол Улсын авлигын эсрэг үндсэн байгууллага болох Авлигатай Тэмцэх Газрыг байгуулсан билээ. Эрүүгийн хуулийг 2002 онд хянан үзэж, 2008 онд нэмэлт, өөрчлөлт оруулж, АТГ-ын мөрдөн шалгах хүрээний хэргүүдийг тусгасан. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг 2002 онд баталсан бөгөөд 2007 онд нэмэлт, өөрчлөлт оруулан, эрүүгийн хариуцлага ногдуулах гэмт хэргийн талаар АТГ-ын мөрдөн байцаах чиг үүргийг тодорхойлсон байна. Мөн АТГ-ын үйл ажиллагаа нь авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах, авлигын гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг хүлээн авч шалгах, хуулиар харъяалуулсан эрүүгийн хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулахаар хязгаарлагддаг, шүүн таслах эрх мэдэл байдаггүйг тэмдэглэх хэрэгтэй.

3. Сонгосон зүйл ангийн тойм

3.1. 5-р зүйл

Авлигаас урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагаа

1. Оролцогч улс бүр эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн нийгмийн оролцоог дэмжсэн, хууль дээдлэх ёс, төрийн үйл хэрэг болон төрийн эд хөрөнгийг зохистойгоор удирдах, шударга байх, ил тод байх, хариуцлага хүлээх зарчмыг илэрхийлсэн үр дүнтэй, уялдаа холбоо бүхий авлигын эсрэг бодлогыг боловсруулж, хэрэгжүүлнэ.

2. Оролцогч улс бүр авлигаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үр дүнтэй үйл ажиллагааг явуулах буюу хөхиүлэн дэмжихийг чармайна.

3. Оролцогч улс бүр авлигаас урьдчилан сэргийлж, тэмцэхэд нийцэхүйц байдлыг тодорхойлох зорилгоор холбогдох эрх зүйн баримт бичиг болон захиргааны арга хэмжээнд тогтмол дүгнэлт хийж байхыг чармайна.

4. Оролцогч улсууд зохих тохиолдолд эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн энэ зүйлд заасан арга хэмжээг хөхиүлэн дэмжиж, хөгжүүлэх чиглэлээр өвөр хоорондоо, түүнчлэн холбогдох олон улсын болон бүс нутгийн байгууллагатай хамтран ажиллана. Ийм хамтын ажиллагаанд авлигаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн олон улсын хөтөлбөр, төсөл багтаж болно.

а. Үндсэн шаардлагууд

5-р зүйлийн дагуу оролцогч улсууд дараах шаардлагыг хангана. Үүнд: (а) нийгмийн оролцоог дэмжсэн, хууль дээдлэх ёс, төрийн үйл хэрэг болон төрийн эд хөрөнгийг зохистойгоор удирдах, шударга байх, ил тод байх, хариуцлага хүлээх зарчмыг илэрхийлсэн үр дүнтэй, уялдаа холбоо бүхий авлигын эсрэг бодлогыг боловсруулж, хэрэгжүүлнэ (1 дэх заалт); (б) энэ зүйлд заасан арга хэмжээг хөхиүлэн дэмжиж, хөгжүүлэх чиглэлээр өвөр хоорондоо, түүнчлэн холбогдох олон улсын болон бүс нутгийн байгууллагатай хамтран ажиллана. (4 дэх заалт). 5-р зүйл нь хууль тогтоох тал дээр онцгой шаардлага тавиагүй боловч оролцогч улсуудад эрх зүйн тогтолцооныхоо суурь зарчмын дагуу авлигаас урьдчилан сэргийлэх өргөн хүрээний бодлого, үйл ажиллагаа боловсруулан хэрэгжүүлэх чиг үүрэг өгч байна. Мөн зүйлийн хүрээнд 1 дэх заалтад (а) авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн өргөн оролцоог дэмжсэн; (б) (i) хууль дээдлэх, (ii) төрийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн зохистой менежмент хэрэгжүүлэх, (iii) шударга байдал, (iv), ил тод байдал, (v) хариуцлагатай байдлын зарчмыг тусгасан уялдаа зохицол бүхий үр нөлөөтэй үйл ажиллагаа боловсруулах, хэрэгжүүлэх, тогтмолжуулахыг шаардаж байгаа юм. Эдгээр үндсэн зорилгыг конвенцийн бусад зүйлд заагдсан заавал хэрэгжүүлэх болон сонгон хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг зохион байгуулах замаар хангана. 5-р зүйлийн 4 дэх заалтад эдгээр зорилгыг хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх тухайд оролцогч улсууд хоорондоо болон холбогдох олон улсын байгууллагатай хамтран ажиллахыг шаардлага болгожээ.

б. 5-р зүйлийн тухайд үнэлгээний багийн олсон мэдээлэл, ажиглалт

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр

Улсын Их Хурлаас 2002 онд баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр нь авлигаас урьдчилан сэргийлэх стратегийг агуулдаг бөгөөд 2004, 2006 онд тус тус нэмэлт, өөрчлөлт хийгджээ. 2006 оны нэмэлт, өөрчлөлтийг 2007 онд УИХ баталсан. Энэхүү хөтөлбөрийг 2002-2010 оны хооронд хоёр үе шаттай хэрэгжүүлж байна. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр гурван бүлэгтэй, тодорхой зорилго, зорилт, зарчим, хэрэгжилтийн хугацааны хуваарь, хүлээгдэх үр дүн, хэрэгжүүлэх үйл ажиллагааг заасан байдаг. Уг хөтөлбөр сонгуулийн тогтолцоог төгөлдөржүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх эрх зүйн орчин бүрдүүлэх, төрийн үйлчилгээг сайжруулах, шүүхийн бие даасан байдлыг хангах, гүйцэтгэх байгууллагуудын үйл ажиллагаа, санхүүг чөлөөлөх, авлигатай тэмцэхэд иргэний нийгмийн оролцоог идэвхжүүлэхийг зорьж байна.

УИХ анх Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэсний зөвлөлийг зохицуулах, удирдах чиг үүрэгтэй байгуулсан байна. Энэхүү хуучин үндэсний зөвлөл нь УИХ-ын дэд даргаар удирдуулсан, бүрэлдэхүүнд нь Ерөнхий шүүгч, Ерөнхий прокурор, Төрийн албаны зөвлөлийн дарга, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга, долоон сайд, агентлагийн дарга нар, төрийн бус байгууллагын төлөөллүүд орж байлаа. 2005 онд төрийн бус байгууллагуудын нэгдсэн бүлэг хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ хийгээд үндэсний зөвлөл тогтмол ажиллагаагүйн улмаас хөтөлбөрийн удирдлага, зохицуулалт хангалтгүй байна гэж дүгнэжээ.

2006 онд Авлигын эсрэг хуулийг шинэчилснээр НҮБ-ын Авилгалын эсрэг конвенцийг бүрэн хэрэгжүүлэх зорилттой нийцүүлсэн. Шинэчилсэн хуулиар Авлигатай Тэмцэх Газрыг Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг манлайлан хэрэгжүүлэх байгууллага байхаар зааж, авлигаас урьдчилан сэргийлэх бодлого үйл ажиллагааг нарийвчлан тодорхойлсон юм. АТГ 2006 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр байгуулагдсан ба тус бие даасан байгууллагын даргыг 2006 оны 12 сарын 27-ны өдөр томилсон байна. АТГ эдүгээ Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг өнөөгийн хэрэгцээ, нөхцөл байдалд нийцүүлэн шинэчлэх ажил хийж байна. Хөтөлбөрийг боловсронгуй болгох чиглэлээр төрийн ба төрийн бус байгууллагын дунд семинар зохион байгуулж, тэдгээр байгууллагын үзэл бодол, саналыг хүлээн авчээ. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 2010 онд дуусаж байгаатай холбогдуулан Авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэх дунд хугацааны хөтөлбөрийг батлуулахаар холбогдох төслийг боловсруулж байна.

АТГ-ын авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа

Авлигын эсрэг хуулийн хоёрдугаар бүлэгт Олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг нарийвчлан тусгасан байна. Үүнд авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд бизнес аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, иргэд, боловсролын байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслийн оролцоог хангах талаар заасан байгаа (5-р зүйл). АТГ байгуулагдмагцаа 100 орчим бизнес эрхлэгчийг урьж уулзсан нь хувийн хэвшлийн оролцоог эрэлхийлж байсны нэг жишээ. Тэдгээр

бизнес эрхлэгчид нээлттэй хэлэлцүүлэгт оролцож, хувийн хэвшилд тулгардаг бэрхшээлийн талаар илүү гүн ойлголт өгч, тэдгээр асуудлыг хэрхэн шийдэх талаар санал зөвлөгөөгөөр хангасан байна. Бизнес эрхлэгчдийн оролцоог гүнзгийрүүлэх үүднээс АТГ Монголын Ажил олгогчдын холбоотой Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан. Энэхүү холбоо нь АТГ-тай хамтран хувийн хэвшлийн хүрээнд авлигын эсрэг үндэсний семинар зохион байгуулсан байна.

Мөн Globe International, Transparency International зэрэг төрийн бус байгууллагуудын сүлжээд авлигатай тэмцэх чиглэлд, ялангуяа орон нутаг, алслагдсан нутаг оронд онц идэвхтэй ажилладаг нь ажиглагдсан. АТГ 2009 оны нэгдүгээр улиралд 21 аймагт ажиллаж буй төрийн бус байгууллагаас тайлан хүлээн авснаа мэдэгдсэн. Мөнхүү Уул уурхайн үйлдвэрийн ил тод байдлын санаачилга хэрэгжих шатандаа байгааг мэдээлжээ. Хоёр дахь удаагийн үнэлгээний тайланг 2009 он 9 дүгээр сард 102 компаниас мэдээлэл цуглуулж авснаар гүйцэтгэнэ.

Авлигын эсрэг хууль улс төрийн яриа хэлцэл, төрийн хяналт, улсын төсөв, төрийн байгууллагын худалдан авалт, лиценз зөвшөөрөл олгох гэх зэрэг төрийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байхыг заасан (6-р зүйл). Энэ заалтыг хэрэгжүүлээгүй нөхцөлд торгууль шийтгэлтэй. Тухайлбал төрийн албан тушаалтан урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх үүргээ биелүүлээгүй бол эрх бүхий албан тушаалтан сахилгын шийтгэл ногдуулдаг (6-ийн 8). Мөн хуульд заасны дагуу Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг хүлээн авсан аж ахуйн нэгж, байгууллага түүний дагуу холбогдох арга хэмжээг заавал авч, хариуг хугацаанд нь өгөх үүрэгтэй бөгөөд энэ үүргээ биелүүлээгүй тохиолдолд 150000-200000 төгрөгөөр торгоно (6-ийн 9). Ялангуяа АТГ-ын урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тухайд үүнийг Авлигын эсрэг хуульд тодорхой тусгасан байгаа. Басхүү АТГ-ын төсвийн тодорхой хэсэг дан урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдахыг заасан байдаг. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсвийг аймаг бүрт хуваарилдаг бөгөөд уг төсвийн 10 хувийг зөвхөн авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор зарцуулахаар Авлигатай тэмцэх газар, аймгийн Засаг дарга, аймгийн төрийн бус байгууллагуудын сүлжээний ахлагчдын хооронд байгуулсан гэрээнд тусган зарцуулж байна.

АТГ-ын мэдэгдэж байгаагаар 2007 оны 9 сараас 2009 оны эхний улирал хүртэл тус газрын мөрдөн байцаах албанд төрийн ба төрийн бус байгууллагын 800 албан тушаалтны авлигын талаар 1182 гомдол, мэдээлэл ирсний 97 хувийг шалгасан байна. Мөн хугацаанд 588 этгээдийн 268 авлигатай холбоотой эрүүгийн хэрэг илэрсний 33 нь улс төрийн албан тушаалтан, 95 нь төрийн захиргааны албан тушаалтан, 121 нь төрийн тусгай албаны ажилтнуудтай холбоотой хэрэг байлаа.

Мөн АТГ төрийн албан тушаалтнаас хөрөнгө, орлогын мэдүүлэг хүлээн авч, шалгах чиг үүрэгтэй. Тус газрын мэдээлснээр 2008 онд 271 өндөр албан тушаалтан, түүнчлэн 53016 төрийн албан хаагч, албан тушаалтан хөрөнгө, орлогын мэдүүлгээ ирүүлсэн байна. (2007-2009 оны байдлаар хөрөнгө, орлогын мэдүүлгээ ирүүлээгүй, хугацаа хожимдуулсан 53 албан тушаалтанд Авлигын эсрэг хуулийн дагуу ажлаасаа халах арга хэмжээг холбогдох байгууллагууд ногдуулаад байна. АТГ хүлээн авч буй хөрөнгө, орлогын мэдүүлгийг шалгахдаа нэмэлт мэдээлэл авч ашиглах боломжтой юм. Тэрчлэн

хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон иргэний нийгмийн байгууллагууд чухал нөлөө үзүүлсэн байна. Сонин хэвлэл, телевизээр хөрөнгө, орлогын мэдүүлгээ өгөх сүүлчийн огноо хүртэл үлдсэн хоногийг зарлаж байлаа. Харин сүүлчийн хугацаа нэгэнт өнгөрмөгц мэдэгдлээ ирүүлээгүй албан тушаалтан нарыг иргэний нийгмийн байгууллагуудад мэдээлсэн.

АТГ Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар харьяалуулсан авлигатай холбоотой хэргийг шалгах эрхтэй байдаг. АТГ авлигын гэмт хэргийг илрүүлэх гүйцэтгэх ажил явуулах нэгжтэй, тэр нь АТГ-ын мөрдөн байцаах албатай уялдаатай ажилладаг. Тэрчлэн АТГ долоо хоногийн турш 24 цагийн шууд утас ажиллуулж олон нийтээс гомдол хүлээн авдаг.

Төрийн албан тушаалтныг авлигаас урьдчилан сэргийлэх удирдамж, ёс зүйн хэм хэмжээ

Үндсэн Хуулийн 46-р зүйлийн 2-т “Монгол Улсын төрийн жинхэнэ албан хаагч ... Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, *ард түмнийхээ тусын тулд, иргэний ёсоор төрийн ашиг сонирхолд захирагдаж ажиллана.*” гэж заасан байдаг. Төрийн албан хаагчдын үйл ажиллагааг 1995 оны Төрийн албаны хуулиар нарийвчлан зохицуулсан байх агаад Авилгалын эсрэг конвенцийн үзэл санаанд нийцүүлэхээр уг хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Энэхүү хуулийн дагуу төрийн албан хаагчид эрх үүргээ ард түмэн болон төрийн ашиг сонирхлын төлөө хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн ёс суртахуун, ёс зүйн үүрэг, сахилга бат, төрийн алба, байгууллагын соёлыг сахиж, төрийн албаны нэр төрийг хамгаалж, хөрөнгө, орлогын мэдүүлгээ өгч, аливаа өөрчлөлтийг холбогдох алба болон олон нийтэд мэдээлэх үүрэгтэй.

Энэхүү хуулийн дагуу төрийн захиргааны байгууллагын албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг Засгийн газар баталж, мөрдүүлж байна. Тэрчлэн төрийн байгууллагууд шүүх, прокурор, цагдаагийн ажилтан, аудитор зэрэг тусгай албаны ажилтнуудын ёс зүйн хэм хэмжээг баталсан. Тухайн ёс зүйн хэм хэмжээгээр тодорхойлсон онцлог заалтаас хамааран байгууллагуудад түүнийг хэрэгжүүлэх механизм бүрдүүлж, хариуцах албан тушаалтныг томилно. Тухайлбал, шүүх байгууллагад Шүүгчдийн сахилгын хороо ёс зүйн хэм хэмжээг сахин мөрдөж байгаа байдалд хяналт тавьдаг.

Төрийн албаны зөвлөл

Монгол Улсын Төрийн албаны зөвлөл 10 жилийн өмнө байгуулагдсан бөгөөд сүүлийн 6-7 жилд бие даасан статустай ажиллажээ. Эдүгээ Монгол Улсад 140000 төрийн албан хаагч ажиллаж байна. Төрийн албаны зөвлөл төрийн албан хаагчийн стандартыг тодорхойлох, тэрхүү стандартад хэрхэн нийцэж буй байдалд хяналт тавих үүрэгтэй. Тус зөвлөл нь авлигатай холбоотой асуудлыг хянан шалгах үүрэгтэй биш боловч Авлигын эсрэг хуулийн дагуу авлигатай холбоотой хэргийг АТГ-т шилжүүлж байх үүрэгтэй.

Тус зөвлөл нь төрийн албан хаагч байх боломжтой хүмүүсийн мэдээллийн сан бүрдүүлдэг. Энэ нь дөрвөн үечлэл бүхий ажиллагаа юм. Үүнд: ерөнхий шалгалт авах,

хувь хүн бүрийн мэргэжлийн түвшинг үнэлэх, ярилцлага авах, тухайн албан тушаалын онцлог бүхий шалгалт (компьютер, хэлний мэдлэг). 2008 оны нэмэлт өөрчлөлтөд дараах зүйл багтжээ. Үүнд: төрийн албан хаагч улс төрийн намын гишүүн бус байх; төрийн гүйцэтгэх албан хаагчдад тодорхой шаардлага тавьсан; Төрийн албаны зөвлөлийн хүрээнд төрийн албан хаагчдын боловсрол сургалтын нэгж байгуулах (эдүгээ хүртэл уг нэгж байгуулагдаагүй байна). Төрийн албаны зөвлөлөөс ёс зүйн хэм хэмжээ, төрийн албан хаагчдыг ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нууцлалын шаардлагыг нэвтрүүлэх хуулийн төсөл боловсруулсан нь эдүгээ УИХ-аар батлагдах нь хүлээгдэж байна.

Улс төрийн бие даасан байдал

Монгол Улсын Үндсэн Хуулийн 16-р зүйлийн 10-т “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. Төрийн зарим төрлийн албан хаагчийн намын гишүүнийг түдгэлзүүлж болно.” гэж заасан. Өөрөөр хэлбэл, төрийн албан хаагч тодорхой хэмжээнд улс төрийн намаас хамааралтай байх боломжтой байсан ба түүхэн нөхцөл байдалд улс төрийн намын гишүүн байх нь төрийн зарим албан тушаалд томилогдох нөхцлийн нэг болдог байжээ. Үүний улмаас төрийн олон албан хаагчийг халж, оронд нь мэдлэг, чадвар, чадавхи, туршлагыг үл харгалзан зөвхөн эрх баригч намын гишүүдийг томилох сөрөг үзэгдэл газар авчээ. Үүнээс иргэдийн итгэл алдрах, төрийн ажлын тогтвортой байдал, мэргэжлийн чадамж алдагдаж, төрийн албан хаагчид үүрэгт ажлаа эзэн ёсоор хийх сэтгэл буурахад хүрсэн байна. Энэ бэрхшээлийг арилгах үүднээс 2008 оны 5 дугаар сард Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, төрийн албан хаагчид улс төрийн намын гишүүнчлэлгүй байхаар тогтоосон байна.

Мөн 2008 оны нэмэлт, өөрчлөлт түр хугацааны томилгоотой холбоотой эрсдлийг арилгажээ. Төрийн албаны тухай хуулийн 17-р зүйлийн 12-т төрийн байгууллага нь албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн төрийн захиргааны албан тушаалд иргэнийг 6 сар хүртэл хугацаагаар түр томилж болно гэж заасан байсан. 2008 онд энэ заалтыг хасаж, сул албан тушаалд тухайн байгууллагад ажиллагчдаас томилохоор заасан. Ингэхдээ тухайн томилогдох ажилтны ажлын гүйцэтгэл, мэргэжлийн түвшинг харгалзана. Шаардлагатай бол төрийн албанд орохоор шалгалтад тэнцсэн хүмүүсээс авч ажиллуулна.

Худалдан авалт

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийг 2005 онд шинэчилсэн. Тус хуулийн 6-р зүйлийн 1-д зааснаар “Худалдан авах ажиллагаанд ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай, өрсөлдөх тэгш боломжтой байх зарчмыг баримтална.” гэжээ. Энэхүү хуулиар төрийн албан хаагчид хувийн ашиг завшаан олох хууль бус саналыг хүлээн авах буюу өөрөө тийм санал

тавихыг хориглосон. Мөн хуулиар ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал гарвал, тухайлбал, өөрийн нь гэр бүлийн гишүүн тендерт өрсөлдөх, тендерт өрсөлдөж байгаа аж ахуйн нэгжид ажилладаг буюу тэндээс цалин авахаар бол дээд албан тушаалтандаа мэдэгдэж, тендер шалгаруулах үйл ажиллагаанд оролцохоос татгалзах үүрэгтэй (50-зүйлийн 1.3. “хувийн ашиг сонирхлын үүднээс хууль бус санал тавих, хүлээж авах зэрэг зөрчил, хууль бус үйлдэл гаргахгүй байх;”); мөн тендерт өрсөлдөх этгээд тендерийн үр дүнд нөлөөлөх зорилгоор хахууль санал болгох, дарамт үзүүлэх тохиолдолд дээд албан тушаалтандаа буюу хууль сахиулах байгууллагад мэдэгдэх үүрэгтэй (50-р зүйлийн 1.4. “тендерт оролцогч гэр бүлийнх нь гишүүн, эсхүл тендерт оролцогч хуулийн этгээдэд гэр бүлийнх нь гишүүн ажилладаг буюу цалин хөлс авдаг зэрэг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй нөхцөл байвал өөрийн шууд харьяалан удирдах албан тушаалтанд мэдэгдэж, тухайн тендер шалгаруулалтыг зохион байгуулах ажиллагаанд оролцохгүй байх”). Мөн, “Дараах нөхцөл байдал тогтоогдвол тендерт оролцогч ерөнхий нөхцөл хангаагүй гэж үзнэ: ... 14.1.6. илт худал мэдээлэл бүхий тендерийн материал ирүүлснийг эрх бүхий байгууллага тогтоосон, 14.1.7. сүүлийн 3 жилийн хугацаанд авилгалын гэмт хэрэг үйлдсэнийг шүүх тогтоосон”. Эдгээр заалт 2007 оны 2 сарын 6-ны нэмэлт өөрчлөлтөөр нэмэгдсэн биш бололтой байна. 2-р зүйлийн 2-т “Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө” гэжээ.

Төрийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах асуудлыг хариуцсан байгууллага нь Сангийн Яам байсан бөгөөд 2006 оноос холбогдох яам, агентлагууд тодорхой босго хүртэлх хэмжээний худалдан авалтаа өөрсдөө хариуцах болсон байна. Тэрхүү босгоос давсан тохиолдолд Сангийн Яамны хариуцах асуудал болно. Сангийн Яам худалдан авалтын тогтолцоог сайжруулах, засгийн газрын худалдан авалтын гэрээг цахим системээр хөөн тооцох арга хэрэгсэлд шилжих шаардлагатайг заасан.

Гомдол хүлээн авч шалгах механизм байдаг ба тендер хуулийн дагуу явагдсангүй гэж үзвэл тендерт оролцогчид Сангийн Яаманд гомдол гаргах эрхтэй.Өнгөрсөн жил ийм төрлийн 70 гомдол хүлээн авчээ.

Аудит

Улсын аудит, шалган байцаах хууль 1995 онд мөрдөгдөж эхэлснээр Үндэсний Аудитын Газар байгуулагдсан. Энэ байгууллага нь төрийн байгууллагуудад, түүнчлэн УИХ, Ерөнхий сайдын хүсэлтээр УИХ-д аудит хийх, төсвийг шалгах, сайн засаглалыг бэхжүүлэх үндсэн чиг үүрэгтэй. Тус байгууллага гүйцэтгэл ба санхүүгийн хяналт тавьдаг. 2008 онд гүйцэтгэлийн 14, санхүүгийн 50 аудит хийгджээ. Аудит хийгдэнгүүт тайланг Ерөнхий сайд, УИХ-ын дарга, мөн шаардлагатай бол Ерөнхийлөгчид хүргүүлнэ. Тэрчлэн нууцын зэрэглэл бүхий мэдээлэл агуулснаас бусад тайланг Интернетэд байршуулна. Эдгээр аудит нь байгууллагуудын арилжааны банкинд дахь дансыг шалгах эрх мэдэл байдаггүй. 2003 онд арилжааны банкинд аудит оруулах заалт бүхий Төрийн аудитын хуулийн төсөл боловсруулсан хэдий ч УИХ батлаагүй юм. Аудитаар зөрчил илрэх аваас хэргийг холбогдох байгууллагад шилжүүлэхээс хэтрэхгүй (тухайлбал авлигатай холбоотой хэргийг АТГ-т шилжүүлэх) байна. Авлигатай холбоотой хэрэг

илэрсний их авлигад хамаарах хэргийн дийлэнх нь уул уурхай, дэд бүтцийн салбарт, бичил авлигын хэргийн дийлэнх нь боловсрол, эрүүл мэндийн салбарт гарчээ.

Энэ бүх урьдчилан сэргийлэх тогтолцоо, стратеги нь Монгол Улс НҮБ-ын Авилгалын эсрэг конвенцийн 5-р зүйлийн дагуу авлигаас урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлж байна гэж болохоор байна.

Монгол Улс НҮБ-ын Авилгалын эсрэг конвенцийн 5-р зүйлийн шаардлагыг тогтвортой хангах арга хэмжээ хэрэгжүүлж байна.

3.2 Конвенцийн 15-р зүйл

Дотоодын төрийн албан хаагчдын хахууль

“Оролцогч улс бүр санаатайгаар үйлдсэн дараахь үйлдлийг гэмт хэрэг гэж тогтооход шаардлагатай байж болох хууль тогтоох болон бусад арга хэмжээг авна:

(а) төрийн албан тушаалтныг албан үүргээ хэрэгжүүлэх явцад нь аливаа үйлдэл хийлгэх эсхүл хийлгэхгүйн тулд тухайн албан тушаалтанд өөрт нь эсхүл өөр этгээд буюу байгууллагад шууд буюу шууд бусаар хууль бус давуу тал олгохыг амлах, санал болгох эсхүл олгох;

(b) төрийн албан тушаалтан өөрийн албан үүргийг хэрэгжүүлэх явцад аливаа үйлдэл хийх эсхүл хийхгүйн тулд өөртөө эсхүл өөр этгээд буюу байгууллагад шууд буюу шууд бусаар хууль бус давуу тал олгохыг шаардаж хясан боогдуулах эсхүл давуу тал авах.”

а. Үндсэн шаардлагууд

15-р зүйлийн дагуу оролцогч улсууд хоёр гэмт хэргийг тодорхойлно. Үүнд: үндэсний төрийн албан тушаалтны идэвхтэй ба идэвхгүй хахууль. Үүнд:

Оролцогч улсууд төрийн албан тушаалтныг албан үүргээ хэрэгжүүлэх явцад нь аливаа үйлдэл хийлгэх эсхүл хийлгэхгүйн тулд тухайн албан тушаалтанд өөрт нь эсхүл өөр этгээд буюу байгууллагад шууд буюу шууд бусаар хууль бус давуу тал олгохыг амлах, санал болгох эсхүл олгохыг (15-р зүйлийн (а) санаатайгаар үйлдсэн тохиолдолд эрүүгийн гэмт хэрэгт тооцох. Энэхүү гэмт хэргийн бүрэлдэхүүн нь төрийн албан тушаалтанд амлах, санал болгох, өгөх явдал болно. Уг гэмт хэргийг тодорхойлохдоо бэлэг буюу аливаа биет зүйлийг санал болгоогүй тохиолдлыг ч бас тооцох ёстой. Тиймээс “хууль бус давуу тал” гэсэн нь биет буюу биет бус, мөнгөн буюу мөнгөн бус шинжтэй байж болохыг илэрхийлнэ. Хууль бус давуу байдлыг төрийн албан тушаалтанд шууд бөгөөд даруй өгсөн байх албагүй. Түүнийгээ амласан, санал болгосон буюу, шууд буюу шууд бус хэлбэрээр олгосон байж болно. Мөн бэлэг, хөнгөлөлт, бусад давуу байдлыг заавал өөрт нь гэлгүй гэр бүлийн гишүүн, улс төрийн байгууллагад нь өгч болно. Зарим улсын хуульд давуу байдлыг амлах буюу санал болгохыг хахууль өгөхийг оролдсон гэдэг зүйл ангид хамруулсан байдаг. Үүнээс бусад тохиолдолд амлах (хахууль өгөгч болон хахууль авагчийн тохиролцоо гэсэн үг), санал

болгохыг (хахууль авч болох тал нь зөвшөөрсөн гэсэн үг хараахан биш) шаардлагатай бол тусгайлан зааж болно. Хууль бус давуу байдал буюу хажууль нь мөн албан үүрэгтэй нь холбогдсон байх ёстой.

Оролцогч улсууд төрийн албан тушаалтан өөрийн албан үүргийг хэрэгжүүлэх явцад аливаа үйлдэл хийх эсхүл хийхгүйн тулд өөртөө эсхүл өөр этгээд буюу байгууллагад шууд буюу шууд бусаар хууль бус давуу тал олгохыг шаардаж хясан боогдуулах эсхүл давуу тал авахыг (15-р зүйлийн (b)) санаатайгаар үйлдсэн тохиолдолд эрүүгийн гэмт хэрэг болгон тодорхойлох ёстой. Энэ нь дээрх гэмт хэргийн идэвхгүй хажуулийн хэлбэр юм. Гэмт хэргийн бүрэлдэхүүн хэсэг нь хажууль нэхэх буюу хүлээн авах. Мөн энэ нь албан үүрэгтэй нь холбоотой байх ёстой. Дээр заасан гэмт хэргийн адил хууль бус давуу байдлыг заавал өөрт нь гэлтгүй, өөр хүнд буюу байгууллагад өгөх байж болно. Мөн давуу байдлыг уул төрийн албан тушаалтан өөрөө буюу зуучлагчаар дамжуулан шууд буюу шууд бусаар нэхсэн буюу хүлээн авсан байна. Энэ гэмт хэргийн оюуны буюу субъектив бүрэлдэхүүн нь албан үүргийнхээ явцыг өөрчлөхийн тулд хууль бус давуу байдал нэхэх буюу хүлээн авах санаархал болно.

b. 15-р зүйлийн хэрэгжилтийн талаарх үнэлгээний багийн олсон мэдээлэл, ажиглалт

Эрүүгийн хуулийн 28-р бүлэгт албан тушаалаа урвуулах, хэтрүүлэх гэмт хэрэг, ялангуяа, хээл хажуулийн (268, 269-р зүйл) гэмт хэргийн тухай зүйл байдаг. Энэ бүлэгт төрийн албан тушаалтан гэдэгт улс төрийн, тусгай, захиргааны болон үйлчилгээний албан хаагчдыг оруулж байна.

Идэвхтэй хажуульдалт

269-р зүйл (Хээл хажууль өгөх):

“269.1. Албан тушаалтанд өөрөө буюу бусдаар дамжуулж хээл хажууль өгсөн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

“269.2. Энэ хэргийг давтан, эсхүл хээл хажуулийн хэрэгт урьд ял шийтгүүлсэн этгээд, түүнчлэн зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2002 оны 9 сард батлагдсан Эрүүгийн хуулийн 269 дүгээр зүйлийн тайлбарт: “Хээл хажууль өгсөн этгээд энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчилж ирсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.” гэж заасан байсан. 2008 оны 2 сард Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, уг тайлбарыг хүчингүй болгосон байна. Энэ тайлбарыг хасснаар хээл хажуулийн гэмт хэргийг илрүүлэхэд улам хүндрэлтэй болсон бөгөөд цаашид энэ тайлбарыг Эрүүгийн хуульд буцаан оруулах талаар АТГ санал боловсруулсан байна.

Энэхүү хэл найруулгыг үзвээс Монгол Улсын авлигын эсрэг хууль тогтоомжид *хожмын давуу байдлыг амлах буюу санал болгохыг* Авилгалын эсрэг конвенцийн дагуу хахуулийн гэмт хэрэгт оруулж тооцоогүй байна.

Идэвхгүй хахуульдалт

268-р зүйл (Хээл хахууль авах):

“268.1. Албан тушаалтан хээл хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүй байх, эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийхээр урьдчилан амлах буюу амлахгүйгээр өөрөө, эсхүл бусдаар дамжуулан хээл хахууль авсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасаж хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”.

Мөн Төрийн албаны 1995 оны хуулийн 15-р зүйлийн 1.6-д төрийн албан хаагч албан тушаалынхаа бүрэн эрхийг хэрэгжүүлсний төлөө бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс мөнгөн шагнал, шан харамж, зээл авах, төлбөргүй буюу хөнгөлөлттэйгээр үйлчлүүлэх зэрэг хууль бус бусад хангамж эдлэхийг хатуу хориглодог. Энэ бол төрийн албан хаагч хувийн хэвшилд давхар хөдөлмөр эрхлэхгүй, улс төрийн нам, олон нийтийн байгууллагад байнгын ажилтнаар харьяалагдахгүй, гуравдагч этгээдийг төлөөлөхгүй байх шалтгаан хүчин зүйлийн нэг юм.

Мөн түүнчлэн 270-р зүйлд “хээл хахууль зуучлах”, 30, 31, 32-р зүйлд төгссөн болон төгсөөгүй гэмт хэрэг (хээл хахуулийг багтаасан), гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэх (хээл хахуулийг багтаасан), гэмт хэрэг үйлдэхээр завдахыг (хээл хахуулийг багтаасан) тодорхойлсон байна.

Гэтэл Монгол Улсын идэвхгүй хахуульдалтын талаарх хууль тогтоомжид төрийн албан тушаалтан хахууль *нэхэх* гэмт хэргийг тооцоогүй орхисон байна.

Монгол Улс НҮБ-ын Авилгалын эсрэг конвенцийн 15-р зүйлийн шаардлагыг хангах зарим нэг арга хэмжээг хэрэгжүүлж байна.

3.3 Конвенцийн 16-р зүйл

Гадаадын төрийн албан тушаалтан болон олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах

“1. Оролцогч улс бүр гадаадын төрийн албан тушаалтан эсхүл олон улсын байгууллагын албан тушаалтныг албан үүргээ хэрэгжүүлэх явцад нь олон улсын үйл ажиллагаа явуулахад хамааруулан бизнесийн буюу зүй бус бусад давуу тал олж авах буюу тийм давуу талаа хадгалах зорилгоор ямарваа үйлдэл хийлгэх эсхүл хийлгэхгүйн тулд тухайн албан тушаалтанд өөрт нь эсхүл өөр этгээд буюу байгууллагад шууд буюу шууд бусаар зүй бус давуу тал олгохыг амлах, санал болгох эсхүл олгох үйлдлийг санаатай

үйлдсэнийг гэмт хэрэг гэж тогтооход шаардлагатай байж болох хууль тогтоох болон бусад арга хэмжээг авна.

2. Оролцогч улс бүр гадаадын төрийн албан тушаалтан эсхүл олон улсын байгууллагын албан тушаалтан өөрийн албан үүргийг хэрэгжүүлэх явцад ямарваа үйлдэл хийх эсхүл хийхгүйн тулд өөртөө эсхүл өөр этгээд буюу байгууллагад шууд буюу шууд бусаар зүй бус давуу тал олгохыг шаардаж хясан боогдуулах эсхүл давуу тал авах үйлдлийг санаатайгаар үйлдсэнийг гэмт хэрэг гэж тогтооход шаардлагатай байж болох хууль тогтоох болон бусад арга хэмжээг авах асуудлыг авч үзнэ.”

а. Үндсэн шаардлага

16-р зүйлийн 1 дэх заалтаар оролцогч улс бүр гадаадын төрийн албан тушаалтан эсхүл олон улсын байгууллагын албан тушаалтныг албан үүргээ хэрэгжүүлэх явцад нь олон улсын үйл ажиллагаа явуулахад хамааруулан бизнесийн буюу зүй бус бусад давуу тал олж авах буюу тийм давуу талаа хадгалах зорилгоор ямарваа үйлдэл хийлгэх эсхүл хийлгэхгүйн тулд тухайн албан тушаалтанд өөрт нь эсхүл өөр этгээд буюу байгууллагад шууд буюу шууд бусаар зүй бус давуу тал олгохыг амлах, санал болгох эсхүл олгох үйлдлийг санаатай үйлдсэнийг гэмт хэрэг гэж тогтооход шаардлагатай байж болох хууль тогтоох болон бусад арга хэмжээг авна. 16-р зүйл гадаадын төрийн байгууллагын албан тушаалтны хахуулийг тэрхүү гадаад улсын нь дотоодын хуулиар гэмт хэрэгт тооцсон байх эсэхийг тооцохгүй юм.

16-р зүйлийн 1 дэх заалтаар оролцогч улс бүр гадаадын төрийн албан тушаалтан эсхүл олон улсын байгууллагын албан тушаалтан өөрийн албан үүргийг хэрэгжүүлэх явцад ямарваа үйлдэл хийх эсхүл хийхгүйн тулд өөртөө эсхүл өөр этгээд буюу байгууллагад шууд буюу шууд бусаар зүй бус давуу тал олгохыг шаардаж хясан боогдуулах эсхүл давуу тал авах үйлдлийг санаатайгаар үйлдсэнийг гэмт хэрэг гэж тогтооход шаардлагатай байж болох хууль тогтоох болон бусад арга хэмжээг авах асуудлыг авч үзнэ гэсэн. Энэ нь дотоодын төрийн албан тушаалтны идэвхгүй хахуульдалтын үйлдлийг эрүүгийн гэмт хэрэгт тооцох тухай 15-р зүйлийн (b)-г гадаадын төрийн албан тушаалтанд мөн адил тусгасан заалт юм.

б. 16-р зүйлийн тухайд үнэлгээний багийн олсон мэдээлэл, ажиглалт

Монгол Улс гадаадын төрийн албан тушаалтан хийгээд олон улсын төрийн байгууллагын албан тушаалтны идэвхтэй болон идэвхгүй хахуульдалтын талаар ямарваа арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна.

Монгол Улс НҮБ-ын Авилгалын эсрэг конвенцийн 16-р зүйлийн шаардлагыг хангах талаар ямарваа арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна.

3.4 Конвенцийн 17-р зүйл

Төрийн албан тушаалтан эд хөрөнгө завших, ашиглан шамшигдуулах буюу бусад аргаар зориулалтын бусаар зарцуулах

“Төрийн албан тушаалтан албан тушаалын нь дагуу өөрт нь итгэж хариуцуулсан аливаа эд хөрөнгө, төрийн буюу хувийн мөнгө эсхүл үнэт цаас, аливаа бусад үнэ бүхий зүйлийг өөрийн эсхүл өөр этгээд буюу байгууллагын ашиг тусад завших, ашиглан шамшигдуулах буюу бусад аргаар зориулалтын бусаар зарцуулах үйлдлийг санаатайгаар үйлдсэнийг гэмт хэрэг гэж тогтооход шаардлагатай байж болох хууль тогтоох болон бусад арга хэмжээг оролцогч улс бүр авна.”

а. Үндсэн шаардлага

Энэ зүйлийн дагуу оролцогч улс бүр төрийн албан тушаалтан албан тушаалын нь дагуу өөрт нь итгэж хариуцуулсан аливаа эд хөрөнгө, төрийн буюу хувийн мөнгө эсхүл үнэт цаас, аливаа бусад үнэ бүхий зүйлийг өөрийн эсхүл өөр этгээд буюу байгууллагын ашиг тусад завших, ашиглан шамшигдуулах буюу бусад аргаар зориулалтын бусаар зарцуулах үйлдлийг санаатайгаар үйлдсэнийг гэмт хэрэг гэж тогтооход шаардлагатай байж болох хууль тогтоох болон бусад арга хэмжээ авна гэж заасан.

Гэмт хэргийн бүрэлдэхүүн хэсэг нь төрийн албан тушаалтан үүрэгт ажилтай нь холбоотойгоор өөрт нь итгэн хариуцуулсан эд хөрөнгийг завших, ашиглан шамшигдуулах буюу бусад аргаар зориулалтын бусаар зарцуулах явдал болно. Үүнд уул төрийн албан тушаалтны ашиг завшааны тухайд буюу өөр этгээд, байгууллагын ашиг сонирхлын төлөө үйлдсэн байх тохиолдол хамрагдана. Гэмт хэргийн объект нь төрийн болон хувийн өмч хөрөнгө сан, үнэт цаас, үнэ бүхий бусад зүйл байна. Конвенцийн энэ зүйлд жижиг хохирлыг байцаан шийтгэх шаардлага тавиагүй).

б. 17-р зүйлийн талаар үнэлгээний багийн олсон мэдээлэл, ажиглалт

Эрүүгийн хуулийн 150-р зүйлд (Бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх) заасан нь:

“150.1.Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн өмчийг итгэмжлэгдэн хариуцсан этгээд завшсан буюу үрэгдүүлсний улмаас бага бус хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

150.2.Энэ хэргийг давтан буюу бүлэглэж үйлдсэн, энэ хэргийн улмаас бусдад үлэмж хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг таван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

150.3. Энэ хэргийн улмаас бусдад их буюу онц их хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хурааж, таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

260-р зүйлд (Дансалсан буюу битүүмжилсэн эд хөрөнгийг үрэгдүүлэх, нуух) мөн л ашиглан шамшигдуулах гэмт хэргийн хууль сахиулах эрх мэдэлтнүүдтэй холбоотой оруулсан заалт байна. Үүнд:

“260.1. Хуулийн байгууллагаас дансалсан буюу битүүмжилсэн эд хөрөнгийг итгэмжлэгдэн хариуцсан этгээд санаатай үрэгдүүлсэн, нуусан, бусдад шилжүүлсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.”

Мөн, 273.1-т (Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах) заасан нь:

“273.1.Төсөв захирагч төрийн өмч, төсвийн хөрөнгийг:

273.1.1.зориулалтын бусаар зарцуулсан;

273.1.2.зах зээлийн дунджаас дээгүүр үнээр эд хөрөнгө худалдан авсан;

273.1.3.нөөцлөх нэрээр хэрэгцээнээс илүү хэмжээгээр бараа бүтээгдэхүүн худалдан авч, мөнгөний эргэлтийг саатуулсан;

273.1.4.зохиомол хомсдол бий болгох замаар бараа бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх үнийг зориудаар өсгөсөн;

273.1.5. төрийн өмчийн болон төсөвт байгууллагын эд хөрөнгийг зах зээлийн дунджаас доогуур үнээр борлуулсан;

273.1.6.улсын төсвийн болон өөрийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа барилга байгууламж, тоног төхөөрөмжийн угсралтад шаардлага хангаагүй бараа бүтээгдэхүүн ашиглах замаар төсөвт өртгийг бүрдүүлж хөрөнгө завшсанаас үлэмж хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

278.3. Энэ хэргийн улмаас их буюу онц их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн 82-р зүйлд хууль тогтоомж зөрчигсдөд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүйгээр бол Төрийн өмчийн хорооны эрх бүхий албан тушаалтан зөрчлийн шинж байдлыг харгалзан шийтгэл ногдуулна гэж заасан байна. 82-р зүйлийн 1 дэх заалтаар төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивласан, бэлэглэсэн, барьцаалсан, зээлдүүлсэн, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулсан бол гэм буруутай албан тушаалтныг 30000-60000 төгрөгөөр торгож, учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр тодорхойлсон байна. Энэчлэн төрийн өмчийн эд хөрөнгийг худалдсан, түрээслүүлсэн бол гэм буруутай этгээдийг 25000-60000 төгрөгөөр торгож, уг хохирлыг нөхөн төлүүлэхээр заажээ.

Гэтэл улсын өмч хөрөнгийг ашиглан шамшигдуулах явдлыг Монгол Улсын хууль тогтоомжид тусгасан байх атлаа НҮБ-ын Авилгалын эсрэг конвенцийн дагуу тэрхүү гэмт хэргийг төрийн албан тушаалтан үйлдсэн байх тохиолдлыг онцлон дурдаагүй байна.

Монгол Улс НҮБ-ын Авилгалын эсрэг конвенцийн 17-р зүйлийн шаардлагыг хангах зарим нэг арга хэмжээг л хэрэгжүүлж байна.

3.5 Конвенцийн 25-р зүйл

Шүүн таслах ажиллагаанд саад учруулах

“Оролцогч улс бүр санаатайгаар үйлдсэн дараахь үйлдлийг гэмт хэрэг гэж тогтооход шаардлагатай байж болох хууль тогтоох болон бусад арга хэмжээг авна:

(а) энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэрэг үйлдсэнтэй холбогдуулан байцаан шийтгэх ажиллагаанд худал мэдүүлэг өгөхийг ятгах, эсхүл мэдүүлэг өгөх буюу нотолгоо гаргахад хөндлөнгөөс оролцох зорилгоор хүч хэрэглэх, заналхийлэх буюу айлган сүрдүүлэх, эсхүл зүй бус давуу талыг амлах, санал болгох эсхүл олгох;

(b) энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэрэг үйлдсэнтэй холбогдуулан шүүн таслах буюу хууль сахиулах албан тушаалтны албан үүргээ хэрэгжүүлэхэд нь хөндлөнгөөс оролцох зорилгоор хүч хэрэглэх, заналхийлэх буюу айлган сүрдүүлэх. Энэ дэд хэсгийн аль ч заалт төрийн албан тушаалтны бусад ангиллыг хамгаалах тухай хууль тогтоомжтой байх оролцогч улсуудын эрхийг хөндөхгүй.”

а. Үндсэн шаардлага

Оролцогч улсууд гэрчийн мэдүүлэг болон үнэн бодит баримт бүрдүүлэх албан тушаалтны үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх зорилгоор ятгах, хүч хэрэглэх, заналхийлэх буюу айлган сүрдүүлэх үйлдлийг эрүүгийн гэмт хэрэгт тооцохыг конвенцийн 25-р зүйлд заасан. Нэг дэх гэмт хэрэг нь эрх бүхий байгууллагад үнэн зөв мэдээлэл баримт өгөх гэрч болон бусад этгээдэд нөлөөлөх оролдлого болно. Оролцогч улсууд энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэрэг үйлдсэнтэй холбогдуулан байцаан шийтгэх ажиллагаанд худал мэдүүлэг өгөхийг ятгах, эсхүл мэдүүлэг өгөх буюу нотолгоо гаргахад хөндлөнгөөс оролцох зорилгоор хүч хэрэглэх, заналхийлэх буюу айлган сүрдүүлэх, эсхүл зүй бус давуу талыг амлах, санал болгох эсхүл олгох үйлдлийг эрүүгийн гэмт хэрэгт үзэхийг конвенцийн 25-р зүйлийн (а)-д заасан. Өөрөөр хэлбэл хахууль зэрэг авлигач арга хэрэгсэл болон хүч хэрэглэхээр сүрдүүлэх зэрэг албадлагын арга хэрэгслийг эрүүжүүлэх үүргийг оролцогч улсууд хүлээн авсан байна.

б. Конвенцийн 25-р зүйлийн (а) болон (b) заалтын талаар үнэлгээний багийн олсон мэдээлэл, ажиглалт

Гэрчид нөлөөлөх зорилгоор ятгах, сүрдүүлэх, хүч хэрэглэх

Эрүүгийн хуулийн 256-р зүйлд заасан нь:

“256.1. Хүч хэрэглэх, эд хөрөнгийг нь устгахаар заналхийлэх, шан харамж өгөх зэргээр гэрч, хохирогчоор худал мэдүүлэг өгүүлсэн, шинжээчээр худал дүгнэлт гаргуулсан, орчуулагчаар худал орчуулуулсан, хэлмэрчээр худал хэлмэрчлүүлсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх

хэмжээний төгрөгөөр торгох, хоёр зуугаас гурван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

256.2.Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг үйлдсэн, эсхүл энэ хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”.

Энэчлэн, 245-р зүйлд заасан нь:

“245.1.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагаанд санаатайгаар саад учруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

245.2.Энэ хэргийг албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурван зуугаас таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”.

Басхүү, 254-р зүйлд заасан нь:

“254.1.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт болон шүүхэд гэрч, хохирогч зориуд худал мэдүүлэг өгсөн, шинжээч зориуд худал дүгнэлт гаргасан, орчуулагч зориуд худал орчуулсан, хэлмэрч зориуд худал хэлмэрчилсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

254.2. Энэ хэргийг шунахайн болон хувийн бусад сэдэлтээр үйлдсэн, эсхүл хүнийг хүнд, онц хүнд гэмт хэрэгт холбогдуулж буюу нотлох баримт хуурамчаар бүрдүүлж, хуурамч мэдүүлэг өгсөн, түүнчлэн энэ хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёроос дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”.

Цаашлаад 254-р зүйлд тодорхойлсон зөрчлийг үйлдсэн этгээдэд Эрүүгийн хуулийн 35-р зүйлийн дагуу хариуцлага хүлээлгэхээр заасан.

Шүүхийн болон хууль сахиулах байгууллагын албан тушаалтанг сүрдүүлэх замаар албан ажилд нь нөлөөлөх

Дээр дурдсанчлан, 245-р зүйлд дараах үйлдлийг эрүүгийн гэмт хэрэгт тооцжээ:

“Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагаанд санаатайгаар саад учруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун цаг хүртэл хугацаагаар

албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

245.2. Энэ хэргийг албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурван зуугаас таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”.

Гэтэл энэ хууль тогтоомжид Авилгалын эсрэг конвенцийн шаардлагын дагуу *шүүх, хууль сахиулах байгууллагын албан тушаалтанд* сүрдүүлэг хэрэглэх үйлдлийн талаар хууль тогтоомжид онцлон дурдаагүй байх юм.

Монгол Улс НҮБ-ын Авилгалын эсрэг конвенцийн 25-р зүйлийн шаардлагыг хангах зарим нэг арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

3.6 Конвенцийн 46-р зүйл

Эрх зүйн харилцан туслалцаа

“1. Оролцогч улсууд энэхүү конвенцоор хамарсан гэмт хэрэгт мөрдөн байцаах, яллах, шүүх ажиллагаа явуулахад эрх зүйн хамгийн өргөн хүрээний туслалцааг бие биедээ үзүүлнэ.

“...”

“9. (а) Хоёр улс тухайн үйлдлийг гэмт хэрэг гэж хоёулаа тогтоосон байх зарчим үйлчлэхгүй тохиолдолд хүсэлт авагч оролцогч улс энэ зүйлийн дагуу туслалцаа үзүүлэх хүсэлтэд хариу өгөхдөө энэхүү конвенцийн 1 дүгээр зүйлд заасны дагуу энэхүү конвенцийн зорилгыг харгалзан үзнэ.

(b) Оролцогч улсууд хоёр улс тухайн үйлдлийг гэмт хэрэг гэж хоёулаа тогтоосон байх зарчим байхгүй гэсэн үндэслэлээр энэ зүйлийн дагуу туслалцаа үзүүлэхээс татгалзаж болно. Гэвч хүсэлт хүлээн авагч оролцогч улс албадлагын арга хэмжээ агуулаагүй эрх зүйн туслалцааг эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн үзүүлнэ. Туслалцаа үзүүлэх хүсэлт нь de minimis шинжтэй асуудалтай эсхүл энэхүү конвенцийн өөр заалтын дагуу хамтран ажиллаж буюу хүссэн туслалцааг үзүүлж болох асуудалтай холбоотой тохиолдолд эрх зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзаж болно.

(c) Хоёр улс тухайн үйлдлийг гэмт хэрэг гэж хоёулаа тогтоосон байх зарчим байхгүй тохиолдолд оролцогч улс бүр энэ зүйлийн дагуу аль болох их хэмжээгээр эрх зүйн туслалцаа үзүүлэх боломжтой байхад шаардлагатай байж болох арга хэмжээ авах асуудлыг авч үзэж болно.

“...”

“13. Оролцогч улс бүр харилцан эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хүсэлтийг хүлээн авах, гүйцэтгэх, эсхүл гүйцэтгүүлэхээр эрх бүхий байгууллагуудад дамжуулах асуудлыг хариуцсан, тийм бүрэн эрхтэй төв байгууллагыг томилно. Хэрэв аливаа оролцогч улсад эрх зүйн туслалцаа

харилцан үзүүлэх өөр тогтолцоотой тусгай бүс буюу нутаг дэвсгэр байдаг бол тухайн улс нь тухайн бүс буюу нутаг дэвсгэрийн хувьд мөн адил чиг үүргийг гүйцэтгэх эрх бүхий төв байгууллагыг тусд нь томилж болно. Эрх бүхий эдгээр төв байгууллага нь туслалцаа үзүүлэх хүсэлтийг шуурхай бөгөөд зохистойгоор гүйцэтгэх буюу дамжуулах явдлыг хангана. Хэрэв эрх бүхий төв байгууллага хүсэлтийг гүйцэтгүүлэхээр эрх бүхий байгууллагад дамжуулж байгаа бол тэрхүү эрх бүхий байгууллага уг хүсэлтийг шуурхай бөгөөд зохистойгоор гүйцэтгэхийг хөхиүлэн дэмжинэ. Энэхүү конвенцийг соёрхон баталсан тухай батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, батласан буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулахдаа оролцогч улс бүр энэхүү зорилгоор томилсон эрх бүхий төв байгууллагынхаа тухай мэдэгдэнэ. Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай хүсэлт болон үүнтэй холбогдсон аливаа мэдээ, мэдээллийг оролцогч улсуудын томилсон эрх бүхий төв байгууллагуудад дамжуулж байна. Энэхүү шаардлага нь ийм хүсэлт, мэдээ, мэдээллийг дипломат шугамаар, түүнчлэн яаралтай нөхцөл байдалд оролцогч улсууд харилцан тохиролцсон нөхцөлд хэрэв боломжтой бол Олон улсын эрүүгийн цагдаагийн байгууллагаар дамжуулан авч байхыг шаардах оролцогч улсын эрхийг хөндөхгүй.”

а. Үндсэн шаардлагууд

Авилгалын эсрэг конвенц оролцогч улсуудад дараах зүйлийг үүрэг болгож байна: (a) 46-р зүйлийн 3 дахь заалтын дагуу эрүүгийн гэмт хэргийг мөрдөн байцаах, яллах, шүүх ажиллагаа, өмч хөрөнгө хураах, нөхөн олгоход эрх зүйн харилцан туслалцааг хэрэгжүүлэх өргөн хүрээний арга хэмжээг авч ажиллах; (46-р зүйлийн 1); (b) энэхүү конвенцийн 26 дугаар зүйлийн дагуу хуулийн этгээд хариуцлага хүлээж болох гэмт хэрэгтэй холбогдуулан мөрдөн байцаах, яллах, шүүх ажиллагаа явуулахад бололцоотой бүхий л хэмжээнд эрх зүйн туслалцааг харилцан үзүүлэх (46-р зүйлийн 2); (c) Оролцогч улсууд банкны нууцлал гэсэн үндэслэлээр энэ зүйлийн дагуу эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхээс зайлсхийхгүй байх (46-р зүйлийн 8); (d) оролцогч улсууд хоорондоо эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ байгуулаагүй тохиолдолд эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлтийн хувьд энэ зүйлийн 9-өөс 29 дэх хэсгийг хэрэглэх (46-р зүйлийн 7).

46-р зүйлийн 9 дэх заалтаар хоёр улс тухайн үйлдлийг гэмт хэрэг гэж хоёулаа тогтоосон байх зарчим үйлчлэхгүй тохиолдолд энэхүү конвенцийн зорилгыг харгалзан үзнэ, үүнд өмч хөрөнгө нөхөн олгох асуудал бас хамаарна. 46-р зүйлийн 9 дэх заалтын (b)-д хоёр улс тухайн үйлдлийг гэмт хэрэг гэж хоёулаа тогтоосон байх зарчим байхгүй ч хүсэлт хүлээн авагч оролцогч улс албадлагын арга хэмжээ агуулаагүй эрх зүйн туслалцааг эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн үзүүлэх тухай заасан нь шинэлэг юм. Хоёр тал тухайн үйлдлийг гэмт хэрэг гэж тогтоогоогүй ч гадаадын төрийн албан тушаалтан буюу олон улсын байгууллагын албан тушаалтан хахуулийн хэрэгт орсон талаарх мэдээлэл солилцох явдал бол үүний нэг жишээ болно (Конвенцийн 16-р зүйлийн 2 дахь заалттай холбоотойгоор 26 дахь заалтад өгсөн

тайлбарыг A/58/422/Add.1 баримт бичгээс үзнэ үү). Мөн конвенц оролцогч улсуудыг 496-р зүйлийн дагуух өргөн хүрээний харилцан туслалцаа үзүүлэх боломжийг бий болгох арга хэмжээнүүд хэрэгжүүлэхийг уриалсан байна (46-р зүйлийн 9 дэх заалтын (с). Оролцогч улсууд хоёр тал тухайн хэргийг эрүүгийн гэмт хэрэгт тогтоосон зарчим эрх зүйн харицлан туслалцаанд үйлчилж байгаа хууль тогтоомж, үйл ажиллагаагаа нягт хянан үзэх хэрэгтэй. Зарим тохиолдолд шинэ хууль тогтоомж шаардлагатай байх болно.

НҮБ-ын Авилгалын эсрэг Конвенц оролцогч улс тус бүрийг эрх зүйн харилцан туслалцааны талаарх хүсэлтийн хүлээн авах, гүйцэтгэх буюу холбогдох эрх бүхий байгууллагад шилжүүлэх төвлөрсөн байгууллага бий болгохыг шаарддаг. Холбогдох эрх бүхий байгууллага нь тухайн ажиллагааны үе шат тутамд өөр өөр байж болох юм. Конвенцийн 46-р зүйлийн 13, 14-т оролцогч улсуудыг 46-р зүйлийн шаардлагын дагуу төв байгууллага бий болгосон тухай болон түүний хүлээн авах хэлний талаар НҮБ-ын Ерөнхий Нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэх үүрэгтэй.

б. Конвенцийн 46-р зүйлийн тухайд үнэлгээний багийн олсон мэдээлэл, ажиглалт

Конвенцийн 46(9)

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхэд тухайн хэргийг хоёр улсад эрүүгийн гэмт хэрэгт тодорхойлсон эсэх нь нөлөөлөх эсэхийг дурдаагүй байна. Ази Номхон Далайн бүлгийн Санхүүгийн ажиллагааны тусгай бүлгийн (APG FATF) Монгол Улсын талаарх 2007 оны тайланд Монгол Улс хоёр тал тухайн хэргийг эрүүжүүлээгүй тохиолдолд эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхийг зөвшөөрөх эсэх нь тодорхойгүй байна. Гэхдээ үнэлгээний багийг тус улсад ажиллах үеэр Хууль Зүй, Дотоод Хэргийн Яам эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлт ирсэн тохиолдолд тухайн хэргийг хоёр талдаа эрүүгийн хэрэг гэж тодорхойлоогүй байсан ч Монгол Улс тэрхүү хүсэлтийг гүйцэтгэнэ гэж баталсан билээ.

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхэд тухайн хэргийг заавал хоёр талдаа эрүүгийн хэрэгт тооцсон байх тухай заалт, зүйл анги байхгүй байна. Үнэлгээний шинжээчдийн тэмдэглэж буйгаар Монгол Улс хоёр талд тухайн хэргийг эрүүгийн хэрэгт тооцсон эсэх асуудал боссон байлаа ч эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхийг зөвшөөрч байгаа гэж холбогдох эрх мэдэлтэн нар мэдэгдсэн байна.

Монгол Улс НҮБ-ын Авилгалын эсрэг конвенцийн 46-р зүйлийн 9 дэх заалтын шаардлагыг хангах зарим нэг арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Конвенцийн 46(13)-р зүйл

Монгол Улс 2008 оны 9 сарын 11-нд НҮБ-ын Ерөнхий Нарийн бичгийн дарга нарын газарт Авилгалын эсрэг Конвенцтой холбоотойгоор эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай хүсэлт хүлээн авах, гүйцэтгэх буюу холбогдох эрх бүхий байгууллагад

шилжүүлэх үүрэг, эрх мэдэл бүхий төв байгууллага нь Монгол Улсын Хууль Зүй Дотоод Хэргийн Яам болохыг мэдэгдсэн (U.N. Doc. No. C.N.641.2008.TREATIES-23).

Уг байгууллагын хаяг:

Монгол Улс, Улаанбаатар 210646,
Худалдааны гудамж 6/1,
Хууль Зүй Дотоод Хэргийн Яам
E-mail: admin@mojha.gov.mn
Web page: www.mojha.gov.mn

Монгол Улс НҮБ-ын Авилгалын эсрэг конвенцийн 46-р зүйлийн 13 дахь заалтын шаардлагыг хангах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

3.7 Конвенцийн 52-р зүйл

Гэмт хэргээс олсон орлогыг шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх, шилжүүлгийг илрүүлэх

“1. Энэхүү конвенцийн 14 дүгээр зүйлийг үл хөндөн оролцогч улс бүр харьяалалд нь багтах санхүүгийн байгууллагуудаас харилцагчийнхаа биеийн байцаалтыг нягталж байх, өндөр дүнтэй дансны гүйлгээний үр шим хүртэгч нь хэн болохыг тодорхойлох талаар боломжит арга хэмжээ авах, төрийн чухал чиг үүрэг гүйцэтгэж байгаа буюу байсан хувь хүн, тэдний гэр бүлийн гишүүд болон ойр холбоотой түншүүдийн нээх гэсэн буюу эзэмшиж буй данс, эсхүл нэрийн нь өмнөөс нээх гэсэн буюу эзэмшиж буй дансанд хатуу хяналт явуулахыг шаардахад шаардлагатай байж болох арга хэмжээг дотоодын хууль тогтоомждоо нийцүүлэн авна. Ийм хатуу хяналт нь сэжигтэй гүйлгээг эрх бүхий байгууллагад мэдээлэх зорилгоор илрүүлэхэд үндэслэлтэйгээр зориулагдсан байх бөгөөд ийм шалгалтыг санхүүгийн байгууллагыг хууль ёсны харилцагчтайгаа бизнесийн үйл ажиллагаа явуулахыг саатуулсан буюу хориглох гэсэн утгаар тайлбарлаж болохгүй.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан арга хэмжээг хэрэгжүүлэхийг хөнгөвчлөхийн тулд оролцогч улс бүр дотоодын хууль тогтоомждоо нийцүүлэн, мөнгө угаахтай тэмцдэг бүс нутгийн, бүс хоорондын болон олон талт байгууллагуудын санаачлагыг удирдлага болгон:

(а) харьяалалд нь багтах санхүүгийн байгууллагаас дансанд нь хатуу хяналт явуулах ёстой хувь хүн, хуулийн этгээдийн төрөл, онцгой анхаарал хандуулах данс ба гүйлгээний төрөл, түүнчлэн тэдгээр данстай холбогдуулан данс нээх, эзэмших, бүртгэл хөтлөх талаархи зохих арга хэмжээний талаар сэрэмжлүүлэг заавар гаргаж;

(b) харьяалалд нь багтах санхүүгийн байгууллагын таньж тогтоосон хувь хүн, хуулийн этгээдээс гадна эдгээр байгууллагаас хатуу хяналт явуулах ёстой тодорхой хувь хүн, хуулийн этгээдийн талаар санхүүгийн эдгээр байгууллагад оролцогч өөр улсын хүсэлтээр эсхүл өөрийн санаачлагаар зохих тохиолдолд мэдэгдэнэ.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсгийн (а) дэд хэсгийн утгаар, энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан хүмүүст хамаарах данс, гүйлгээний зохистой бүртгэлийг санхүүгийн байгууллагууд нь зохих хугацаанд хөтлөж байх явдлыг хангах арга хэмжээг оролцогч улс бүр авч хэрэгжүүлэх бөгөөд энэ бүртгэлд наад зах нь харилцагчийн, мөн боломжтой бол дансны гүйлгээг хүлээн авагчийн хэн болох тухай мэдээллийг агуулбал зүйтэй.

4. Энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргээс олсон орлогыг шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх, шилжүүлгийг илрүүлэх зорилгоор оролцогч улс бүр бодитоор оршдоггүй болон зохицуулалт бүхий санхүүгийн бүлэгт харьяалагддаггүй банк байгуулахаас зохицуулагч ба хяналтын байгууллагуудынхаа тусламжтайгаар урьдчилан сэргийлэх талаар үр дүнтэй бөгөөд зохистой арга хэмжээ авна. Түүнчлэн, оролцогч улсууд санхүүгийн байгууллагуудаасаа ийм байгууллагуудтай банкны корреспондент харилцаа тогтоох, тийм харилцаагаа үргэлжлүүлэхээс татгалзах, түүнчлэн бодитоор оршдоггүй болон зохицуулалт бүхий санхүүгийн бүлэгт харьяалагддаггүй банк дансыг нь хэрэглэхийг зөвшөөрч буй гадаадын санхүүгийн байгууллагуудтай харилцаа тогтоохоос хамгаалахыг шаардах асуудлыг авч үзэж болно.

5. Оролцогч улс бүр дотоодын хууль тогтоомжийнхоо дагуу төрийн зохих албан тушаалтнуудын санхүүгийн байдалтай холбогдсон мэдээллийг нээж байх үр дүнтэй тогтолцоо тогтоох асуудлыг авч үзэх бөгөөд үл биелүүлэх тохиолдолд ногдуулах зохих хариуцлагыг заана. Түүнчлэн энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргээс олсон орлогыг мөрдөн байцаах, шаардах, буцааж олгох шаардлагатай тохиолдолд дээрх мэдээллийг оролцогч бусад улсын эрх бүхий байгууллагуудтай хуваалцахыг зөвшөөрөхөд шаардлагатай байж болох арга хэмжээг авах асуудлыг оролцогч улс бүр мөн авч үзнэ.

6. Гадаад улсад санхүүгийн данс эзэмшдэг буюу гарын үсэг зурах эрхтэй буюу өөр эрх эдэлдэг төрийн зохих албан тушаалтнаас уг харилцаагаа эрх бүхий зохих байгууллагад мэдээлэх ба уг данстай холбоотой зохих бүртгэл хөтлөж байхыг шаардах талаар дотоодын хууль тогтоомжийнх нь дагуу шаардлагатай байж болох арга хэмжээг авах асуудлыг оролцогч улс тус бүр авч үзнэ. Үл биелүүлэх тохиолдолд ногдуулах зохих хариуцлагыг эдгээр арга хэмжээнд мөн заана.”

а. Үндсэн шаардлагууд

Оролцогч улсууд Конвенцийн 14-р зүйлд харшлахгүйгээр үндэсний хуулийнхаа дагуу санхүүгийн байгууллагуудыг (а) үйлчлүүлэгчдийн хэн болгохыг таньж тогтоох; (б) өндөр дүнтэй дансны гүйлгээний үр шим хүртэгч нь хэн болохыг тодорхойлох талаар боломжит арга хэмжээ авах; (в) төрийн чухал чиг үүрэг гүйцэтгэж байгаа буюу байсан хувь хүн, тэдний гэр бүлийн гишүүд болон ойр холбоотой түншүүдийн нээх гэсэн буюу эзэмшиж буй данс, эсхүл нэрийн нь өмнөөс нээх гэсэн буюу эзэмшиж буй дансанд хатуу хяналт явуулахыг шаардах арга хэмжээ авахыг үүрэг болгодог. Эдгээр заалтыг оролцогч улсууд мөнгө угаахын эсрэг үйлчлүүлэгчийг таньж тогтоох, дансны тайлан

хөтлөх, мэдээлэх шаардлага бүхий эрх зүйн болон захиргааны нийтлэг дэглэмийн хүрээнд ойлгох ёстой.

Эдгээр арга хэмжээний хэрэгжилтийг дэмжих үүднээс оролцогч улсууд хууль тогтоомжийнхоо дагуу болон бүс нутгийн, бүс хоорондын хийгээд олон улсын байгууллагын үйл ажиллагааны хүрээнд дараах үүрэг хүлээнэ. Үүнд: (a) харьяалалд нь багтах санхүүгийн байгууллагын таньж тогтоосон хувь хүн, хуулийн этгээдээс гадна эдгээр байгууллагаас хатуу хяналт явуулах ёстой тодорхой хувь хүн, хуулийн этгээдийн талаар санхүүгийн эдгээр байгууллагад оролцогч өөр улсын хүсэлтээр эсхүл өөрийн санаачлагаар зохих тохиолдолд мэдэгдэх; дансны төрөл хэлбэр болон онцгой анхаарал татаж буй гүйлгээний талаар мэдэгдэх; данс нээсэн, хадгалсан, тайлан хөтөлсөн талаар мэдэгдэх; (b) хууль тогтоомжийнхоо дагуу өөр оролцогч улсын хүсэлтээр буюу өөрийн талын санаачилгаар дансанд нь санхүүгийн байгууллагууд хатуу хяналт тавих учиртай этгээдүүдийн хэн болох талаар санхүүгийн байгууллагуудад мэдэгдэх; (c) санхүүгийн байгууллагуудаас 52-р зүйлийн 1 дэх заалтад заасан этгээдийн дансны мэдээ тайланг зөв зүйтэй хөтөлж байх, үйлчлүүлэгч болон гүйлгээний хүлээн авагчийг таньж тогтоож байх; (d) бодитоор оршдоггүй болон зохицуулалт бүхий санхүүгийн бүлэгт харьяалагддаггүй банк байгуулахаас урьдчилан сэргийлэх.

Оролцогч улсууд мөн дараах зүйлсийг анхаарах үүрэг хүлээнэ: (a) төрийн зохих албан тушаалтнуудын санхүүгийн байдалтай холбогдсон мэдээллийг нээж байх үр дүнтэй тогтолцоо тогтоох асуудлыг авч үзэх бөгөөд үл биелүүлэх тохиолдолд ногдуулах зохих хариуцлагыг заана; (b) тогтоосон гэмт хэргээс олсон орлогыг мөрдөн байцаах, шаардах, буцааж олгох шаардлагатай тохиолдолд дээрх мэдээллийг оролцогч бусад улсын эрх бүхий байгууллагуудтай хуваалцахыг зөвшөөрөх; (c) гадаад улсад санхүүгийн данс эзэмшдэг буюу гарын үсэг зурах эрхтэй буюу өөр эрх эдэлдэг төрийн зохих албан тушаалтнаас (i) уг харилцаагаа эрх бүхий зохих байгууллагад мэдээлэхийг шаардах; (ii) уг данстай холбоотой зохих бүртгэл хөтөлж байхыг шаардах; (iii) үл хэрэгжүүлсэн тохиолдол ногдуулах хариуцлагыг тодорхойлох.

Оролцогч улсууд санхүүгийн байгууллагуудаас мөн дараахыг шаардаж болно. Үүнд: (a) бодитой оршдоггүй буюу зохицуулалт бүхий санхүүгийн бүлэгт багтаддаггүй банктай харилцагч банк болох буюу үргэлжлүүлэн харилцахаас татгалзах; (b) бодитой оршдоггүй буюу зохицуулалт бүхий санхүүгийн бүлэгт багтаддаггүй банкинд өөрийн дансыг ашиглуулдаг гадаадын санхүүгийн байгууллагатай харилцахаас татгалзах.

б. Конвенцийн 52-р зүйлийн тухайд үнэлгээний багийн олсон мэдээлэл, ажиглалт

1 дэх заалт: Харилцагчийг таньж тогтоох

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуульд харилцагчийн мэдээллийг шалгах аргаар заасан байдаг. Дараах тохиолдолд эрх бүхий этгээд нь уг хуулийн 5-р зүйлийн 1 дэх заалтын дагуу харилцагчийн мэдээллийг шалгах үүрэгтэй:

“5.1. Дараах тохиолдолд энэ хуулийн 4.1-д заасан этгээд харилцагчийн талаархи мэдээллийг шалгах үүрэгтэй:

5.1.1. санхүүгийн үйлчилгээ үзүүлэхийн өмнө;

5.1.2. 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/ буюу түүнээс дээш үнийн дүнтэй гүйлгээ хийхийн өмнө;

5.1.3. хоорондоо холбоо бүхий хэд хэдэн удаагийн гүйлгээний тус бүрийн үнийн дүн нь энэ хуулийн 5.1.2-т заасан хэмжээнээс бага боловч нийт үнийн дүн нь 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/ буюу түүнээс дээш үнийн дүнтэй бөгөөд энэхүү гүйлгээ нь энэ хуулийн 5.2-т заасан мэдээллийг гаргаж өгөхөөс зайлсхийх зорилго агуулсан гэж үзэх үндэслэл байгаа бол;

5.1.4. харилцагчийн талаар өмнө авсан мэдээллийн үнэн зөв эсэхийг шалгах шаардлагатай бол;

5.1.5. гадаад төлбөр тооцооны гүйлгээ хийхийн өмнө;

5.1.6. тухайн харилцагчийг буюу гүйлгээг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой гэж үзэх бусад үндэслэл байгаа бол”.

Харилцагчаас дараах мэдээллийг гаргуулж авна:

“5.2.1. харилцагч нь иргэн бол түүний эцэг /эх/-ийн нэр, нэр, оршин суугаа хаяг, регистрийн дугаар, холбоо барих утасны дугаар, иргэний үнэмлэхийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

5.2.2. харилцагч нь хуулийн этгээд бол түүний нэр, хаяг, улсын бүртгэлийн болон татвар төлөгчийн дугаар, харилцах утасны дугаар, улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, удирдлагын талаархи дэлгэрэнгүй танилцуулга;

5.2.3. тухайн гүйлгээний утга, эцсийн хүлээн авагчийн тухай мэдээлэл;

5.2.4. бэлэн бус шилжүүлэг хийлгэсэн этгээдийн тухай мэдээлэл.”.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор банкууд харилцагчаа танин мэдэх тухай тогтоомжийн 2-р зүйлийн 1 дэх заалтаар “Банкны байгууллага харилцагчаа танин мэдэх шаардлагын дагуу харилцагчаасаа шаардлагатай мэдээлэл гаргуулан авах, хянан шалгах эрхтэй”. Мөн 2-р зүйлийн 4 дэх заалт “хэрэв харилцагч энэхүү тогтоомжийн 2-р зүйлийн 2 дахь заалтад дурдсан мэдээллийг гаргаж өгөхөөс татгалзвал (Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийн 5-р зүйлийн 2 дахь заалттай нийцнэ) банк данс нээх, гүйлгээ хийх, санхүүгий бусад үйлчилгээ үзүүлэхээс татгалзах үүрэгтэй” гэж заасан байна.

“”Харилцагчийн мэдээллийг хянан шалгах” гэдэг нь харицлагчийн танин тогтоох, хэн болохыг нь албан ёсны баримт бичиг, улсын бүртгэл, бусад мэдээллийг ашиглан шалгах, Монгол Улсын хуулиар хориглоогүй бусад мэдээллийг цуглуулахыг хэлнэ” (1-р зүйлийн 3.1). Үүний тулд “Банк дотоод цогц бодлого, журмуудыг боловсруулах” (1-р зүйлийн 4), “харилцагчдын эрсдлийн үзүүлэлт бүрдүүлэх, өндөр эрсдэл бүхий харилцагчид болон ердийн гүйлгээнээс онцгой гүйлгээг хянан ажиглах” ((1-р зүйлийн 5) ёстой. Бас 2-р зүйлийн 6 дахь заалтын 1-р хэсэгт банкинд дараахыг хоригложээ: “нэргүй, дугаарласан данс нээх, худал нэрийн дор гүйлгээ хийх, хаагдсан дансыг

ашиглах.” Тэрчлэн зохих анхаарал сэрэмжтэй байх (2-р зүйлийн 7), тусгай хяналт хийх (3-р зүйлийн 1) үүргийг тодорхойлсон ба банкууд дотоод бодлого журмаа боловсруулах, батлах, хяналт тавих ажилтан томилох (4-р зүйлийн 1) шаардлагууд багтсан байна.

2 дахь заалт: Хатуу хяналт болон мэдээлэл

Мөн ямар ч гүйлгээнд харилцагчдад хатуу хяналт тавих талаар Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуульд заасан нь:

- “6.1.1. 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/ буюу түүнээс дээш үнийн дүнтэй гүйлгээ;
- 6.1.2. тухайн гүйлгээний утга нь тодорхой бус;
- 6.1.3. энэ хуулийн 3.2-т заасан жагсаалтад орсон улсаар дамжуулан хийсэн гүйлгээ;
- 6.1.4. бэлэн бус шилжүүлэг хийсэн, эсхүл шилжүүлэг хийлгэсэн этгээдийн тухай бүрэн мэдээлэлгүй;
- 6.1.5. энэ хуулийн 3.2-т заасан жагсаалтад орсон улсын төрийн албан тушаалтан болон улс төрийн намын удирдлагын нэр дээр хийгдэх гүйлгээ;
- 6.1.6. тухайн харилцагчийн урьд нь хийж байснаас өөр бөгөөд утга нь тодорхойгүй гүйлгээ.”

Сэжигтэй болон мөнгөн гүйлгээг мэдээлэх тухай тогтоомжийн 1-р зүйлийн 1-д “энэхүү тогтоомжийн зорилго нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үүднээс сэжигтэй мөнгөн гүйлгээг илрүүлэх, сэжигтэй гүйлгээний талаарх мэдээлийн аюулгүй байдлыг хангах, сэжигтэй болон мөнгөн гүйлгээний талаарх мэдээллийг банкны удирдлага, ажилтан нараас Монгол Банкны Санхүүгийн мэдээллийн алба, холбогдох бусад байгууллагад дамжуулах механизмыг зохицуулахад оршино” гэжээ. Санхүүгийн мэдээллийн алба нь үнэлгээний баг тус улсад ажиллах үеэр тухайн данс мөнгө угаах буюу терроризмыг санхүүжүүлэх зорилгод ашиглагдаж байна гэж сэжиглэх үндэслэлтэй тохиолдолд гүйлгээнд нь хатуу хяналт тавихын дээр захиргааны цаашдын лавлагаа хийнэ гэдгээ баталсан.

Тус тогтоомжийн 1-р зүйлийн 3.1-д зааснаар сэжигтэй гүйлгээний талаарх мэдээлэл гэдэг нь “хүлээн авагчийн нэр, хаяг бүрхэг, эсвэл гүйлгээ нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх сэжиг бүхий байдал, тэрхүү гүйлгээг хийлгэсэн харилцагчийн мэдээллийн талаар банкнаас Санхүүгийн мэдээллийн албанд Монгол Банкны баталсан маягтаар ирүүлсэн мэдээлэл байна”. Энэхүү тогтоомжид мөнгөн гүйлгээний мэдээлэл орсон нь сонирхол татаж байна. Үүнд: мөнгөн гүйлгээ гэдэг нь “үндэсний буюу гадаадын валют, олон улсын гүйлгээнд өргөн хэрэглэгддэг чек, нэхэмжлэх, үнэт цаас оролцсон гүйлгээний талаар банкнаас Санхүүгийн мэдээллийн албанд Монгол Банкны баталсан маягтаар ирүүлсэн мэдээлэл байна” гэжээ. Уг шаардлага нь биелсэн нөхцөлд банкууд сэжигтэй гүйлгээний мэдээллийг 24 цагийн дотор (2-р зүйлийн 1), мөнгөн гүйлгээний мэдээллийг ажлын 7 хоногийн дотор дамжуулах үүрэгтэй (3-р зүйлийн 1). Санхүүгийн мэдээллийн алба сэжигтэй болон мөнгөн гүйлгээний тухайд Тагнуулын ерөнхий Газартай харилцан ойлголцлолын санамж бичиг зуралцсан бөгөөд ийм санамж бичгийг АТГ-тай байгуулахыг зорьж байгаа гэж мэдэгдсэн.

Санхүүгийн өөр өөр байгууллагуудын хамтын ажиллагааг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаар Монгол Банк ба Монголын Гаалийн ерөнхий газрын ажиллагааны тухай тогтоомж зэрэг баримт бичгээр зохицуулдаг байна. Санхүүгийн мэдээллийн албаны тухайд Монгол Банкны бүрэлдэхүүнд ажилладаг бөгөөд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй юм (1-р зүйлийн 1).

Санхүүгийн мэдээллийн албаны мэдэгдсэнээр 16 банк тус нэгжийн стандартыг хангасан ба Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэл өгөх үүрэгтэй 8 төрлийн байгууллага байдаг байна. Үүнд: банк, даатгалын компани, үнэт цаасны брокер, хадгаламж зээлийн хоршоод, барьцаат зээлийн цэг, валют арилжааны цэг, мөрийтэй тоглоомын газар, банк бус санхүүгийн байгууллагууд. Санхүүгийн мэдээллийн алба нь мэдээлэл хүлээн авах талд анхаарал тавин ажиллаж ирсэн ба тэрхүү мэдээллийг шинжлэх, холбогдох байгууллагуудад (АТГ, Ерөнхий прокурор, Цагдаагийн газар, ТТГ) шилжүүлэх шаардлагатай байна. Санхүүгийн мэдээллийн алба нь мөн Монгол Банкны хүрээнд хамтран ажиллах зөвлөлтэй, тэр зөвлөлд нь АТГ гэх зэрэг хууль сахиулах байгууллагууд ордог бөгөөд улирал тутамд хуралддаг байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор банкууд харилцагчаа танин мэдэх тухай тогтоомжийн 6-р бүлэгт Төрийн байгууллагатай хамтран ажиллах гэсэн гарчгийн дотор тэрхүү мэдээллийг яаж ашиглах талаар дурдсан байна. 6-р зүйлийн 1-ийн дагуу “банкууд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаарх дотоод бодлого журмуудыг хэрэгжүүлэх үүднээс хууль тогтоомжийн дагуу Монгол Банк, төрийн бусад байгууллагатай хамтран ажиллах”-ыг заажээ.

Гэтэл НҮБ-ын Авилгалын эсрэг Конвенцийн 52-р зүйлийн шаардлагын дагуу төрийн чухал чиг үүрэг гүйцэтгэж байгаа буюу байсан хувь хүн, тэдний гэр бүлийн гишүүд болон ойр холбоотой түншүүдийн дансанд хатуу хяналт явуулах талаар Монгол Улсын хууль тогтоомжид заагаагүй байна. Үнэлгээний баг Монгол Улсад ажиллах үеэр Санхүүгийн мэдээллийн алба олон улсын хэмжээний улс төрийн зүтгэлтний дансыг хатуу шалгадаг боловч Монголын улс төрийн зүтгэлтний дансыг хатуу шалгадаггүй гэж баталсан.

3 дахь заалт: Харилцагчийн мэдээлэл

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийн 5-р зүйлийн 1-д заасан мэдээллийн сацуу 8-р зүйлийн 1-д харилцагчдын гүйлгээ, хаасан дансны файл, баримт бичгүүдийг 5-аас багагүй жил хадгалахаар заажээ.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор банкууд харилцагчаа танин мэдэх тухай тогтоомжийн “Мэдээлэл хадгалах” гарчиг бүхий 5-р бүлэгт банкууд гүйлгээний холбогдох бүртгэл мэдээллийг 5 жилээс доошгүй хугацаагаар хадгалах (5-р зүйлийн 1), харилцагчийн нэр, хаяг бүхий баримт бичгийг 5 жилээс доошгүй хугацаагаар (5-р зүйлийн 2) хадгалах, шүүх шаардсан тохиолдолд

харилцагчийн мэдээллийг гаргаж өгөхөд бэлэн байлгахгаар (5-р зүйлийн 3) заасан байна.

4 дэх заалт: Бодитой оршдоггүй банк

Монгол Улсын Банкны хуулийн 4-р зүйлд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж болох банкны төрлүүдийг тодорхойлсны зэрэгцээ бодитой оршдоггүй банкны (shell bank) үйл ажиллагааг хориглосон байна. Тэрчлэн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор банкууд харилцагчаа танин мэдэх тухай Монгол Банкны 2007 оны тогтоомжийн 2-р зүйлийн 6-д Монгол дахь банкуудыг бодитой оршдоггүй банк болон тэдгээртэй холбоотой эрх зүйн этгээдүүдийн санхүүгийн гишүүн болохыг хориглосон байна.

5, 6 дахь заалт: Санхүүгийн мэдээллийг нээх

Авлигын эсрэг хуулийн 3-р бүлгийн дагуу төрийн албан хаагчид хөрөнгө, орлогын мэдүүлгээ ирүүлэх үүрэгтэй (НҮБ-ын Авилгалын эсрэг Конвенцийн 5-р зүйл). Хуулийн 4-р зүйлийн дагуу дараах албан тушаалтан нар хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах үүрэгтэй:

“4.1.1. төрийн улс төр, захиргаа, тусгай албан тушаалд байнга, эсхүл түр хугацаагаар томилогдсон буюу сонгогдсон албан хаагч;

4.1.2.төрийн болон орон нутгийн өмчит, түүнчлэн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон захиргааны албан тушаалтан;

4.1.3. олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, Ерөнхий захирал;

4.1.4. төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу түр буюу байнга гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах болон гүйцэтгэх ажилтан;

4.1.5. энэ хуулийн 3.1.9-д заасан сонгуульд нэр дэвшигч”.

Дээр дурдсан этгээдүүд Авлигын эсрэг хуулийн 10-р зүйлийн 3-т зааснаар Улсын Их Хурлаас баталсан “Хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хадгалах журам”-ын дагуу гадаад, дотоод дахь дансыг оролцуулан бүх хөрөнгө, орлогоо мэдүүлэх ёстой. Уг этгээдүүд хөрөнгө, орлогын мэдүүлгээ хугацаа хожимдуулж гаргасан, эсхүл бүртгүүлээгүй буюу санаатай худал мэдүүлсэн бол энэ нь түүнийг албан тушаалаас нь огцруулах, түдгэлзүүлэх, халах үндэслэл болдог (13.5).

Төрийн өндөр албан тушаалтнуудын хөрөнгө, орлогын мэдүүлгийг “Төрийн мэдээлэл” сэтгүүлд нийтэлнэ. Авлигын эсрэг хуулийн 14-р зүйлийн 1-ийн дагуу үүнд дараах албан тушаалтнууд багтана:

“14.1.1.Монгол Улсын Ерөнхийлөгч;

14.1.2.Улсын Их Хурлын дарга, дэд дарга, гишүүн;

14.1.3.Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, дэд сайд;

14.1.4. Үндсэн хуулийн цэцийн дарга, түүний орлогч, гишүүн;

- 14.1.5.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга;
- 14.1.6.Улсын ерөнхий прокурор, түүний орлогч;
- 14.1.7.Монгол банкны Ерөнхийлөгч, тэргүүн дэд, дэд ерөнхийлөгч;
- 14.1.8.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга;
- 14.1.9.Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга;
- 14.1.10.Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга;
- 14.1.11.Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга;
- 14.1.12.Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга;
- 14.1.13.Санхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүн, Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн;
- 14.1.14. Үндэсний статистикийн газрын дарга, дэд дарга;
- 14.1.15.Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, гишүүн;
- 14.1.16. Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн дарга;
- 14.1.17.Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүн;
- 14.1.18.Ерөнхий аудитор, түүний орлогч;
- 14.1.19.Засгийн газрын агентлагийн дарга;
- 14.1.20.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга;
- 14.1.21.Аймаг, нийслэлийн Засаг дарга.

Гэтэл эдгээр заалт нь албан тушаалтнуудад тэрхүү үүсвэрээс авсан мэдээллээ Авилгалын эсрэг Конвенцийн 52-р зүйлийн 5-ын дагуу авлигын хэргийг мөрдөн байцаах зорилгын үүднээс бусад улстай солилцох эрх олгоогүй байх юм.

Монгол Улс Авилгалын эсрэг Конвенцийн 52-р зүйлийн шаардлагын дагуу ихэнх арга хэмжээг хэрэгжүүлж байгаа боловч эдгээрийг амьдралд бүрэн нэвтрүүлээгүй байна.

3.8 Конвенцийн 53-р зүйл

Эд хөрөнгийг шууд буцаан олгох арга хэмжээ

“Оролцогч улс тус бүр дотоодын хууль тогтоомждоо нийцүүлэн:

(а) энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргийг үйлдэх замаар олж авсан эд хөрөнгийг өмчлөх эрх буюу өмчлөлийг тогтоох зорилгоор өөрийн шүүхэд иргэний хэрэг үүсгэхийг оролцогч өөр улсад зөвшөөрөхөд шаардлагатай байж болох арга хэмжээг авч;

(b) энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргийн улмаас хохирсон оролцогч өөр улсад ийм гэмт хэргийг үйлдсэн этгээдээр хохирлыг нөхөн төлүүлэх буюу арилгуулах шийдвэр гаргахыг өөрийн шүүхэд зөвшөөрөхөд шаардлагатай байж болох арга хэмжээг авч;

(c) энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргийг үйлдэх замаар олж авсан эд хөрөнгийн хууль ёсны өмчлөгч болох талаарх оролцогч өөр улсын шаардлагыг хүлээн зөвшөөрөхийг өөрийн шүүх буюу эрх бүхий байгууллагад эд хөрөнгийг хураан авах шийдвэр гаргах үед нь зөвшөөрөхөд шаардлагатай байж болох арга хэмжээг авна. ”

a. Үндсэн шаардлагууд

Конвенцийн 53-р зүйлээр оролцогч улсууд: (a) өөр оролцогч улс авлигын гэмт хэргээр олсон өмч хөрөнгийг өмчлөх эрх буюу өмчлөлийг тогтоох зорилгоор шүүхийн байгууллагадаа иргэний хэрэг үүсгэхийг зөвшөөрөх ((a) дэд заалт); (b) гэмт хэргийн улмаас хохирсон өөр оролцогч улсад ийм гэмт хэргийг үйлдсэн этгээдээр хохирлыг нөхөн төлүүлэх буюу арилгуулах шийдвэр гаргахыг өөрийн шүүхэд зөвшөөрөх ((b) дэд заалт); (c) гэмт хэргийг үйлдэх замаар олж авсан эд хөрөнгийн хууль ёсны өмчлөгч болох талаарх оролцогч өөр улсын шаардлагыг хүлээн зөвшөөрөхийг өөрийн шүүх буюу эрх бүхий байгууллагад эд хөрөнгийг хураан авах шийдвэр гаргах үед нь зөвшөөрөх ((c) дэд заалт) үүрэг хүлээдэг. Эдгээр заалтыг хэрэгжүүлэхэд иргэний хууль, тогтоомж, захиргааны дүрэм журамд нэмэлт өөрчлөлт оруулж, Конвенцийн энэхүү заалтуудын хэрэгжилтэд учирч болох саад тотгорыг арилгах шаардлагатай байж болно. 53-р зүйл нь бусад оролцогч улсад өмч хөрөнгийг буцаан авах, нэхэмжлэлээ баталгаажуулах үүднээс дотоодын шүүх ажиллагаанд байлцахыг зөвшөөрсөн эрх зүйн орчин бүхий оролцогч улсуудад чиглэсэн юм.

b. 53-р зүйлийн тухайд үнэлгээний багийн олсон мэдээлэл, ажиглалт

Монгол Улсын одоогийн хууль тогтоомжид Авилгалын эсрэг Конвенцид оролцогч бусад улсууд Монгол Улсын шүүхэд гэмт хэргээр олж авсан өмч хөрөнгийг өмчлөх эрх олж авах буюу өмчлөлийг тогтоох нэхэмжлэл гаргахыг зөвшөөрсөн заалт байхгүй байна. Гэхдээ мөрдөн байцаалтын явцад тухайн өмч хөрөнгө гадаад улсаас гаралтай, НҮБ-ын Авилгалын эсрэг Конвенцийн хүрээний гэмт хэргээр олдсон болох нь тогтоогдвол Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 42, 43-р зүйлийн дагуу хохирогч этгээдийг иргэний нэхэмжлэгчээр тогтооно. Хохирогч, иргэний нэхэмжлэгч, гадаад улсын нэрийн өмнөөс өргөдөл гаргагчийг тогтоох зорилгоор байцаан шийтгэх үйл ажиллагаа эхлүүлэхэд Эрүүгийн хуулийн 401-р зүйлийг хэрэглэх боломжтой. Үүнийг гүйцэтгэхдээ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн заалтууд төдийгүй олон улсын гэрээ хэлэлцээр, НҮБ-ын Авилгалын эсрэг Конвенцийн заалтуудыг мөрдөх ёстой. Ерөнхийдөө оролцогч улс Авилгалын эсрэг Конвенцийн 53-р зүйлийн (a) заалтын дагуу Монгол Улсын шүүхэд иргэний хэрэг нэхэмжлэх боломжгүй байна.

Тиймээс гадаад улсын холбогдох байгууллагын төлөөлөгч энэхүү зааврыг хэрэгжүүлэхэд оролцож болох юм. Хэрэв энэ нь боломжгүй бол, мөн олон улсын гэрээ хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол хүлээн авсан баримт бичгийг заавар өгсөн гадаадын байгууллагад буцаан өгөх ба чингэхдээ үл хэрэгжих болсон шалгааныг дурдах болно. Цаашлаад, Эрүүгийн хуулийн 49-р зүйлээр гэмт хэргээр олж авсан, түүний дотор авлигаар олсон өмч хөрөнгийг хураах тухай заасан байдаг. Үүнийг гадаад улсын нэрийг өмнөөс өмч хөрөнгийг хураан авахад Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн эрх зүйл харилцан туслалцааны талаарх 401-р зүйлийн 1, 2 дахь заалт болон НҮБ-ын Авилгалын эсрэг Конвенцтой хослуулан хэрэглэж болох юм. Гэхдээ бодит амьдралд Монгол Улсын шүүх гадаад оролцогч улсын гаргасан нэхэмжлэлийг хүлээн авах эсэх нь бүдэг байна.

Монгол Улс НҮБ-ын Авилгалын эсрэг Конвенцийн 53-р зүйлийн шаардлагыг хангах зарим арга хэмжээг хэрэгжүүлж байна.

4. Монгол Улс Конвенцийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлсэн байдлын талаар үнэлгээний багийн олсон мэдээлэл

1. Дурдсан заалтууд хууль тогтоомжид хэрхэн тусгагдсан бэ?

Монгол Улс НҮБ-ын Авилгалын эсрэг Конвенцийн 46-р зүйл (Эрх зүйн харилцан туслалцаа), ялангуяа уг зүйлийн 13 дахь заалтын шаардлагын дагуу арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж байна. Монгол Улс Авилгалын эсрэг Конвенцийн 5-р зүйлийн (Авлигаас урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагаа) шаардлагад нийцэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлж байна.

Монгол Улс Авилгалын эсрэг Конвенцийн 17-р зүйлийн (Төрийн албан тушаалтан нар улсын өмчийг ашиглан шамшигдуулах, зориулалт бусаар зарцуулах) шаардлагын дагуу ихэнх арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Гэхдээ улсын өмч хөрөнгө шамшигдуулахыг аливаа иргэнд холбогдуулж тодорхойлсон, түүнд нь төрийн албан тушаалтан нар багтаж байгаа гэж дам ойлгогдохоос биш НҮБ-ын Авилгалын эсрэг Конвенцид заасанчлан *төрийн албан тушаалтан* улсын өмч шамшигдуулах гэдгийг хууль тогтоомжид онцолж заагаагүй байх юм. Монгол Улс Авилгалын эсрэг конвенцийн 46-р зүйл, тухайлбал 9 дэх заалтын шаардлагын дагуу ихэнх арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Мөн тус улс эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх эрмэлзэлтэйгээ илэрхийлсэн боловч хууль тогтоомждоо энэ талаар тусгаагүй байна.

Монгол Улс Авилгалын эсрэг Конвенцийн 52-р зүйлийн (гэмт хэргээр олсон өмч хөрөнгийг шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх) шаардлагыг хангах чиглэлээр ихэнх арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Харин конвенцийн үзэл баримтлалын дагуу улс төрийн зүтгэлтэн нарын дансанд нарийвчилсан хяналт тавьдаггүй байна. Бас санхүүгийн мэдээлэл гаргаж өгөх талаарх хууль тогтоомжийн заалт нь ийм эх үүсвэрээс авсан мэдээллийг Конвенцийн шаардлагын дагуу бусад оролцогч улсуудтай хуваалцахыг албан тушаалтнуудад зөвшөөрөөгүй байна.

Монгол Улс НҮБ-ын Авилгалын эсрэг Конвенцийн 15-р зүйлийн (дотоодын төрийн албан тушаалтны хахуулийн хэрэг) дагуу шаардлагатай зарим арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Гэхдээ идэвхтэй хахуульдалтын талаарх тус улсын хууль тогтоомжид Авилгалын эсрэг Конвенцийн дагуу *ирээдүйд давуу тал олгохоор амлах буюу санал болгох* явдлыг тусгаагүй байна. Мөн идэвхгүй хахуульдалтын талаарх хууль тогтоомжид Авилгалын эсрэг Конвенцийн дагуу *төрийн албан тушаалтан хахууль нэхэх* явдлыг тусгаагүй байна. Монгол Улс мөн НҮБ-ын Авилгалын эсрэг Конвенцийн 25-р зүйлийн (шүүн таслах ажиллагаанд саад учруулах) дагуу зөвхөн зарим нэг арга хэмжээг л хэрэгжүүлсэн байна. Энэ талаар тус улсын хууль тогтоомж нь шүүн таслах ажиллагаанд саад болох зорилгоор шүүхийн болон хууль сахиулах байгууллагын албан тушаалтанг дарамтлах асуудлыг уг Конвенцийн шаардлагын дагуу тусгаагүй байна.

Мөнхүү Монгол Улс НҮБ-ын Авилгалын эсрэг Конвенцийн 53-р зүйлийн (өмч хөрөнгө нөхөн олгох) шаардлагын дагуу зарим арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Гэхдээ ерөнхийдөө оролцогч гадаад улс тус Конвенцийн дагуу Монгол Улсын шүүхэд иргэний шугамаар гомдол гаргах боломжгүй байна. Түүнчлэн Монгол Улсын шүүхүүд оролцогч гадаад улсын гаргасан гомдлыг хүлээн авах эсэх нь эргэлзээтэй байна.

Монгол Улс НҮБ-ын Авилгалын эсрэг Конвенцийн 16-р зүйлийн (гадаадын төрийн албан тушаалтан буюу олон улсын төрийн байгууллагын албан тушаалтны хахууль) шаардлагыг хангах арга хэмжээ аваагүй байна.

2. Дээр дурдсан заалтуудыг амьдралд хэрхэн хэрэгжүүлж байна вэ?

Монгол Улс авлигын эсрэг тэмцэх эрмэлзэл багагүй байгаагаар харуулсан ч авлигатай тэмцэх тус улсын хууль тогтоомж, бүтэц зохион байгуулалт харьцангуй шинэ тутам байгаа тул бүрэн бэхжээгүй байна. Тиймээс Монгол Улс НҮБ-ын Авилгалын эсрэг Конвенцийн энэхүү тайланд холбогдох ихэнх заалтыг хэрэгжүүлэх шатандаа явж байгаа гэж хэлж болохоор байна. Мөн үнэлгээний баг тус улсад ажиллаж байх хугацаанд Конвенцийг хэрэгжүүлэх тодорхой алхмууд хийгдсэн нь тодорхой харагдаж байв. Монгол Улсад Конвенцийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаарх зөвлөмжийг энэхүү тайланд өгүүлсэн болно.

5. Монгол Улсад хийсэн үнэлгээний үр дүнд тулгуурлан өгч болох зөвлөмж

Үнэлгээний баг Монгол Улсад ажиллах үеэр тус улс авлигын эсрэг хууль тогоомж, бүтэц, зохион байгуулалтаа боловсронгуй болгох чиглэлээр багийн шинжээчдээр зөвлөмж гаргуулах хүсэлтэйгээ илэрхийлсэн билээ. Монгол Улс мөн НҮБ-ын Авилгалын эсрэг Конвенцийн заавал хэрэгжүүлэх заалтуудын дагуу арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх талаар, авлигатай тэмцэх Монгол Улсын үйл ажиллагааг хэрхэн нийтэд нь эрчимжүүлэх талаар зөвлөмж хүссэн билээ.

Үүний учир дараах зөвлөмжийг боловсруулсан болно:

а. НҮБ-ын Авилгалын эсрэг Конвенцийн заалтуудын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаарх зөвлөмж

Эрх зүй, хууль тогтоомжийг сайжруулах

1. НҮБ-ын Авилгалын эсрэг Конвенцийн 15-р зүйлтэй нийцүүлж дотоодын төрийн албан тушаалтны идэвхтэй хахуульдалтын хэрэгт ирээдүйд хахууль өгөхөөр амлах буюу санал болгох явдлыг багтаан тусгаж хууль тогтоомждоо нэмэлт, өөрчлөлт оруулах;
2. НҮБ-ын Авилгалын эсрэг Конвенцийн 15-р зүйлтэй нийцүүлж дотоодын төрийн албан тушаалтны идэвхгүй хахуульдалтын хэрэгт төрийн албан тушаалтан хахууль шаардах явдлыг багтаан тусгаж хууль тогтоомждоо нэмэлт, өөрчлөлт оруулах;

3. НҮБ-ын Авилгалын эсрэг Конвенцийн 16-р зүйлтэй нийцүүлж гадаадын төрийн байгууллагын болон олон улсын байгууллагын албан тушаалтны идэвхтэй хахуульдалтын хэргийг эрүүгийн гэмт хэрэг болгон тодорхойлж Эрүүгийн хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулах;
4. НҮБ-ын Авилгалын эсрэг Конвенцийн 16-р зүйлтэй нийцүүлж гадаадын төрийн байгууллагын болон олон улсын байгууллагын албан тушаалтны идэвхгүй хахуульдалтын хэргийг эрүүгийн гэмт хэрэг болгон тодорхойлж Эрүүгийн хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулах;
5. НҮБ-ын Авилгалын эсрэг Конвенцийн 17-р зүйлтэй нийцүүлж төрийн албан тушаалтан улсын өмч хөрөнгийг ашиглан шамшигдуулах явдлыг онцлон зааж холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, Уг гэмт хэргийг Авлигатай тэмцэх газар харьяалан мөрдөн байцаалтын ажиллагаа явуулахаар холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах;
6. НҮБ-ын Авилгалын эсрэг Конвенцийн 25-р зүйлтэй нийцүүлж шүүн таслах ажиллагаанд саад учруулах зорилгоор шүүх болон хууль сахиулах байгууллагын албан тушаалтанд сүрдүүлэг хэрэглэх явдлыг онцлон зааж холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах;
7. НҮБ-ын Авилгалын эсрэг Конвенцийн 46(9)-р зүйлтэй нийцүүлж хоёр тал тухайн хэргийг эрүүгийн хэрэгт тооцоогүй, Монгол Улсын хууль тогтоомжид үүнийг тодорхойлоогүй тохиолдолд эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх боломжийг хууль тогтоомжид онцлон тусгах;
8. НҮБ-ын Авилгалын эсрэг Конвенцийн 52-р зүйлтэй нийцүүлж дотоодын улс төрийн зүтгэлтнүүдийн данс гүйлгээг нарийвчлан шалгах талаар мөнгө угаахын эсрэг хууль тогтоомждоо нэмэлт, өөрчлөлт оруулах;
9. НҮБ-ын Авилгалын эсрэг Конвенцийн 52-р зүйлтэй нийцүүлж санхүүгийн талаар гаргуулсан мэдээллийг Конвенцийн оролцогч улсуудтай солилцох талаар Авлигын эсрэг хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулах;
10. НҮБ-ын Авилгалын эсрэг Конвенцийн 53-р зүйлтэй нийцүүлж Конвенцийн оролцогч улсууд өмч хөрөнгө нөхөн олгох хэргээр Монгол Улсын шүүхэд байлцах талаар Эрүүгийн байцаан шийтгэх хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулах.

b. Авлигатай тэмцэх үйл ажиллагааг сайжруулах талаарх зөвлөмж

Хууль тогтоомжийг боловсронгуй болгох

1. НҮБ-ын Авилгалын эсрэг Конвенцийн авлигаас урьдчилан сэргийлэх стратегийг дэмжих талаарх 2-р бүлэг, ялангуяа 5-р зүйлийн шаардлагад нийцүүлж дараах эрх зүйн арга хэмжээг хэрэгжүүлэх замаар авлигаас урьдчилан сэргийлэх стратегийг бэхжүүлэх:
 - a. Эдүгээ төслөөр байгаа Төрийн албан хаагчдын Ёс зүйн хэмжээ, төрийн албан хаагчдын ашиг сонирхлын зөрчил, нууцлалтай холбоотой дүрэм журмуудыг батлах;
 - b. Бизнесийн лицензийн талаарх хууль тогтоомждоо нэмэлт өөрчлөлт оруулах замаар бизнес үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авах үйл ажиллагааг хялбаршуулах, одоогийн нүсэр тогтолцоон дахь авлигын эрдслийг бууруулах;

- c. Банкны талаарх хууль тогтоомжийг авлигын эсрэг хууль тогтоомжтой уялдуулж шаардлагатай тохиолдолд баримт мэдээлэл гаргаж өгөх боломжтой болгон нэмэлт, өөрчлөлт оруулах;
 - d. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн талаарх хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулж, хэвлэл мэдээллийн хэрэгслийг өмчлөгч нарыг танин тогтоох явдлыг илүү нээлттэй ил тод болгох;
 - e. Одоогийн тогтоомжоор аудитын байгууллага зөвхөн Монгол Банкнаа хадгалагдаж буй мэдээллийг авах эрхтэй байгаа тул банк, аудитын талаарх тогтоомжуудад нэмэлт өөрчлөлт оруулж, Үндэсний Аудитын Газар төрийн байгууллага, төрийн өмчийн компаниудтай холбоотой бүх дансны мэдээллийг гаргуулан авах боломжтой болгох.
2. НҮБ-ын Авилгалын эсрэг Конвенцийн тодорхой хэргүүдийг эрүүгийн гэмт хэргээр тодорхойлох, хууль мөрдүүлэх талаарх 3-р бүлгийн шаардлагад нийцүүлж АТГ байгуулагдахаас өмнө батлагдсан Банкны хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж банкууд шууд АТГ-т мэдээлэл гаргаж өгдөг болгох (Банкны хуулийн одоогийн хувилбарт банкууд мэдээлэл гаргаж өгөхдөө эхлээд прокурорын зөвшөөрөл авдаг).

Институцийн чадавхийг бэхжүүлэх, сургалт зохион байгуулах

1. НҮБ-ын Авилгалын эсрэг Конвенцийн авлигаас урьдчилан сэргийлэх стратегийг дэмжих талаарх 2-р бүлгийн шаардлагад нийцүүлж дараах урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх:
- a. Төрийн албаны зөвлөлийн дэргэд төрийн албан хаагчдын боловсролыг дээшлүүлэх, сургалт зохион байгуулах, төрийн албанд ажилтан авахдаа шударга байдлын сорил явуулах нэгж байгуулах (энэ нь Монгол Улсын хууль тогтоомжид заагдсан боловч амьдралд хэрэгжиж эхлээгүй байгаа);
 - b. Төрийн байгууллагын худалдан авалт, гэрээлэлтийн менежмент, шүүлт хийх цахим систем боловсруулах талаар техникийн тусламж авах;
 - c. Төрийн яам тус бүрт өмнө нь Монгол Улсын төрийн байгууллагын худалдан авалт, авлигын эсрэг шаардлагыг хангаж чадаагүй компаниудын хар данс хөтлөх;
 - d. Ёс зүйн хэм хэмжээний үлгэр загвар боловсруулах талаар хувийн хэвшилд туслах;
 - e. Монголын Ажил олгогчдын холбооноос санал болгосон “Авлигын эсрэг менежмент санаачилгыг” хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх.
2. НҮБ-ын Авилгалын эсрэг Конвенцийн тодорхой хэргүүдийг эрүүгийн гэмт хэргээр тодорхойлох, хууль мөрдүүлэх талаарх 3-р бүлгийн шаардлагад нийцүүлж мөрдөн байцаах прокурорын институцийг бэхжүүлэх талаар дараах арга хэмжээг хэрэгжүүлэх:
- f. АТГ-ын мөрдөн байцаагчдын чадавхийг бэхжүүлэх талаар тусламж хүсэх, үүнд санхүүгийн ярвигтай хэргийн мөрдөн байцаалт, мөрдөн байцаалтын тусгай арга ажиллагаа хэрэглэх талаар сургалт зохион

- байгуулах, Энэ гэмт хэргийн шийдвэрлэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа, прокурорын хяналтын үйл ажиллагаануудын хоорондын уялдаа холбоог сайжруулж бүртгэлийн сүлжээтэй холбогдох, Гол нь мөрдөн байцаалт, мөрдөн байцаалтын тусгай ажиллагаа явуулах арга, аргачлалыг зааж сургах;
- g. АТГ-аас өөр байгууллагад шилжүүлсэн авлигын хэргийн араас хөөн хянах тогтолцоо бий болгох, үүнд шаардлагатай тохиолдолд АТГ тухайн хэргийг өөр дээрээ авч мөрдөн байцаахыг зөвшөөрөх;
 - h. Ерөнхий Прокурорын газарт авлигын хэрэг шийдэх чиглэлээр мэргэшсэн прокуроруудтай болгох, тэдгээр нь санхүүгийн ярвигтай хэргийг шийдэх талаар тусгай сургалтад хамрагдсан байх;
 - i. Ерөнхий Прокурорын газар болон АТГ-ын хооронд хамтарсан ажиллагааг өргөжүүлж авлигын хэргийн мөрдөн байцаалт, прокурорын хяналтыг эрчимжүүлэх;
 - j. АТГ улс даяар олон нийтийн мэдлэг ухамсрыг дээшлүүлэх аян өрнүүлж олон нийтэд авлигын тухай болон авлигач зан үйл, нийгэмд авлига ямар хор хөнөөлтэй байдаг талаар мэдээлэл хүргэх. Үнэлгээний баг Монгол Улсад ажиллах үеэр хүн амын дийлэнх хэсэг хахуулийг авлигын цорын ганц хэлбэр гэж ойлгодог нь мэдэгдсэн;
 - k. Авлигын эсрэг тэмцэлд оролцогч талуудыг авлигын эсрэг төрөл бүрийн үйл ажиллагаанд оролцуулах замаар тэдгээрийн хооронд оршиж буй итгэлийн хомсдлыг арилгах.
3. НҮБ-ын Авилгалын эсрэг Конвенцийн эрх зүйн харилцан туслалцааг бэхжүүлэх талаарх 46-р зүйлийн шаардлагад нийцүүлж дараах арга хэмжээг хэрэгжүүлэх:
- a. Холбогдох шүүгч, прокурор нарыг олон улсын хамтын ажиллагааны чиглэлээрх шилдэг туршлагын талаар сургалтад хамруулах;
 - b. Эрх зүйн туслалцаа гаднаас авах болон гадагш өгөхтэй холбоотой хүсэлтийг хүлээн авсан, илгээсэн, дамжуулсан болон хэрэгжсэн байдлыг хөөн хянахад Монгол Улсын төрийн байгууллагуудыг татан оролцуулах төвлөрсөн тогтолцоо бий болгох.
4. НҮБ-ын Авилгалын эсрэг Конвенцийн авлигаас урьдчилан сэргийлэх талаарх 52-р зүйлийн шаардлагад нийцүүлж Санхүүгийн мэдээллийн алба болон АТГ-ын холбогдох албан тушаалтан нарт зориулан санхүүгийн талаар гаргуулсан мэдээллийг солилцох талаар чадавхи бэхжүүлэх сургалт зохион байгуулах дэмжлэг хүсэх, мөн Сэжигтэй гүйлгээний мэдээллийг авлигын хэргийг мөрдөн байцаах хэрэгсэл болгон бэлтгэх, түгээх, ашиглах талаар чадавхи бэхжүүлэх дэмжлэг хүсэх.

6. Зөвлөмжид суурилан боловсруулсан Үйл ажиллагааны төлөвлөгөөний санал

[Монгол Улс энэхүү тайлангийн 5 дахь хэсэгт тодорхойлсон зөвлөмжийг хүлээн зөвшөөрсний дараа Монгол Улстай хамтран ярилцаж тус үнэлгээний багийн мэргэжилтнүүдээр төлөвлөгөөг зохиолгохыг НҮБ-ын Нарийн бичгийн даргын газарт санал болгож байна.]

